

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО  
ОРОН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ХЭДИЙ Ч  
ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН  
БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ДАА-2022/20-7-ШТА-ГА



Дархан-Уул аймаг  
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Ахлах аудитор У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Аудитор Б.Алтанзул**

Утас: 70373089 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

**Аудитор З.Мөнгөнцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

**Аудитор О.Мягмарсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn

## АГУУЛГА

|                                                                                                                                                                                                                    |    |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Аудитын тайлан баталгаажуулсан тушаал: .....                                                                                                                                                                       | 7  |
| БҮЛЭГ А. ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН<br>БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ<br>ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН УЯЛДАА ХАНГАГДСАН БАЙНА ..... | 9  |
| А.1. Үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой орон нутгийн<br>бодлого, чиглэл уялдаатай байна .....                                                                                         | 9  |
| А.1.1. Дархан-Уул аймгийн хөгжлийн бодлого, зорилтууд төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар<br>баримтлах дунд хугацааны бодлоготой уялдсан байна .....                                                                 | 9  |
| А.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг шаардлагатай үед хийгээгүй байна .....                                                                                                                                    | 9  |
| А.1.3 Дархан-Уул аймгийн ЗДҮАХ-ийг боловсруулахдаа бүх талуудын оролцоог хангасан<br>байна .....                                                                                                                   | 10 |
| А.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд<br>шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна. ....                                                          | 10 |
| А.2.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх төсвийн тооцоолол тодорхойгүй байна. ....                                                                                                                               | 10 |
| А.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын санхүүжилтэд орон<br>нутгийн оролцоо хангалтгүй байна. ....                                                                                   | 11 |
| А.2.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр<br>дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв батлагдаагүйгээс зарим арга хэмжээ хэрэгжээгүй<br>байна. ....                         | 12 |
| А.3. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй<br>байна .....                                                                                                              | 12 |
| А.3.2. Орон нутгийн онцлогт тохирсон зохицуулалтыг бодлогын баримт бичигт тусган<br>хэрэгжүүлж байна .....                                                                                                         | 12 |
| А.3.3. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна .....                                                                                                                              | 13 |
| А.3.4. Зарим арга хэмжээний хэрэгжилтийг бодитой тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг<br>журмын дагуу үнэлээгүй байна .....                                                                                    | 14 |
| БҮЛЭГ Б. САНГУУДЫН ХӨРӨНГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨ<br>БАГАТАЙ БАЙНА .....                                                                                                                           | 15 |
| Б.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөтэй байна<br>.....                                                                                                                     | 15 |
| Б.1.1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах<br>арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлжээ .....                                                                            | 15 |
| Б.1.2. Цахим мэдээллийн сангийн бүртгэлийн ашиглалт хангалтгүйгээс тоо мэдээ зөрүүтэй<br>тайлагнаж байна .....                                                                                                     | 16 |
| Б.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан<br>байна .....                                                                                                            | 16 |
| Б.2. Төсөл, хөтөлбөрүүдийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө сул байна .....                                                                                                                          | 17 |
| Б.2.1. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжсэн байна<br>.....                                                                                                                   | 17 |
| Б.2.2. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө сул байна .....                                                                                                                                | 18 |
| Б.2.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулж 2021 оноос хөрөнгө баталж<br>эхэлсэн байна .....                                                                                                        | 20 |
| Б.3. Дэд сангийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, төрийн байгууллагуудтай хамтарч<br>ажиллаагүй байна. ....                                                                                                        | 20 |
| Б.3.1. Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, төрийн байгууллагуудтай хамтран<br>ажиллаагүй байна .....                                                                                                 | 20 |
| Б.3.2. Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл итгэлийн зээлийг олон хүнд<br>жижиг зээл хэлбэрээр олгосон нь зээлийн зориулалт алдагдан, чанаргүй зээл болжээ .....                               | 22 |
| Б.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн 31.5 хувь нь мэргэжлээрээ<br>хөдөлмөр эрхэлж байна .....                                                                                             | 26 |

|                                                                                                                                                                                                            |    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Б.4.1 Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан журмыг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна .....                                         | 26 |
| Б.4.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн 32.0 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна .....                                                                                       | 27 |
| Б.5. “Цар тахлын үед аж ахуй эрхлэлтийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд 2 дэд хөтөлбөр, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 8 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлжээ                              | 29 |
| Б.5.1. Ажилгүйдлийн даатгалын сангаас цар тахлын үед ажлын байраа хадгалсан ААНБ-ын даатгуулагчид 974,800.0 мянган төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна. ....                                               | 29 |
| Б.5.2. Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлийн дагуу нийгмийн даатгалын хөнгөлөлтөд 2021 онд давхардсан тоогоор ААНБ-ын 9,809 даатгуулагч хамрагдаж даатгуулагчийн тоо өмнөх оноос 4.8 хувиар өсжээ ..... | 30 |
| Б.5.3. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөлд 119 залуучуудыг хамруулснаас 63 хувийг байнгын ажлын байранд зуучилжээ. ....                                                                                   | 31 |
| Б.5.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтөд судалгаа хийгдээгүй байна .....                                                                                                     | 31 |
| Холбогдох байгууллагаас ирсэн санал: .....                                                                                                                                                                 | 33 |
| ДҮГНЭЛТ: .....                                                                                                                                                                                             | 37 |
| ЗӨВЛӨМЖ: .....                                                                                                                                                                                             | 37 |
| Хавсралт 1 .....                                                                                                                                                                                           | 39 |
| Хавсралт 2 .....                                                                                                                                                                                           | 42 |
| Хавсралт 3 .....                                                                                                                                                                                           | 44 |
| Хавсралт 4 .....                                                                                                                                                                                           | 46 |
| Хавсралт 5 .....                                                                                                                                                                                           | 48 |
| Хавсралт 6 .....                                                                                                                                                                                           | 50 |

## Товчилсон үгийн тайлбар

|          |                                                                  |
|----------|------------------------------------------------------------------|
| ААНБ     | Аж ахуйн нэгж, байгууллага                                       |
| АБДХ     | Ажлын байрыг дэмжих хөтөлбөр                                     |
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт                    |
| АМЗҮ     | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ                              |
| АМЧБО    | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох                               |
| ЖДҮ      | Жижиг дунд үйлдвэр                                               |
| ЖДҮДТ    | Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв                                 |
| ЗГҮАХ    | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр                          |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                                        |
| ЗДҮАХ    | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр                            |
| ЗХЭДХ    | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр                  |
| МБС      | Мэргэжлийн боловсролын сургууль                                  |
| МБСБ     | Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага                       |
| МБСГ     | Мэргэжлийн боловсрол сургалтын газар                             |
| МБСДС    | Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан                        |
| МХЭДХ    | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр                      |
| ОНОХНЗТ  | Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл         |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                                        |
| СХС      | Сум хөгжүүлэх сан                                                |
| ХБББ     | Хөгжлийн бодлогын баримт бичиг                                   |
| ХБИ      | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн                                       |
| ХБИАБДХ  | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр        |
| ХБИДХ    | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөр                    |
| ХЗЗ      | Хөдөлмөрийн зах зээл                                             |
| ХНХС     | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд                                |
| ХНХЯ     | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам                                |
| ХЖДҮХАХМ | Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| ХХЕГ     | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар                   |
| ХХҮГ     | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар                           |
| ХЭАЗ     | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл                               |
| ХЭДС     | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан                                   |
| ХЭҮЗ     | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл                              |
| ШШГА     | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба                                   |

## Хүснэгтийн товьёг

| №  | Тайлбар                                                                  | Хуудасны дугаар |
|----|--------------------------------------------------------------------------|-----------------|
| 1  | МУ-ын 2016-2014 оны дунд хугацааны бодлого, орон нутгийн ХБББ-ийн уялдаа | 8               |
| 2  | Дунд хугацааны ХБББ-ийн жагсаалт                                         | 9               |
| 3  | Санхүүжилтийн эх үүсвэрийн судалгаа                                      | 11              |
| 4  | Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын судалгаа                 | 12              |
| 5  | ХЭДС-ийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн байгууллагын судалгаа          | 12              |
| 6  | ХЭАЗ-ийн 2016-2021 оны төсөв, гүйцэтгэлийн судалгаа                      | 13              |
| 7  | АМЧБО сургалтад хамрагдсан иргэдийн тоо                                  | 15              |
| 8  | Ажлын байрны захилга, ажилд зуучлах иргэдийн тоо                         | 15              |
| 9  | Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл           | 16              |
| 10 | Гадаадын зээл, тусламжийн орлогын задаргаа                               | 17              |
| 11 | СХС-аар бий болсон ажлын байрны судалгаа                                 | 18              |
| 12 | Зээлийн үлдэгдлийн судалгаа                                              | 18              |
| 13 | ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэг                                      | 19              |
| 14 | ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэгийн зээлийн үлдэгдэл                  | 20              |
| 15 | Төсвийн төсөл, батлагдсан төсвийн харьцуулалт                            | 21              |
| 16 | ХЭДС-ийн төсвийн бүрдүүлэлт                                              | 22              |
| 17 | ХЭҮЗ болон ХНХС-ийн баталсан тогтоол, удирдамж                           | 24              |
| 18 | Ажил байрыг дэмжих хөтөлбөрийн зээл олголт                               | 25              |
| 19 | Гарааны бизнесийг дэмжих зээл олголт                                     | 25              |
| 20 | Зорилтот төслийн зээл олголт                                             | 27              |
| 21 | Дархан-Уул аймгийн МБСБ-ын санхүүжилт                                    | 28              |
| 22 | 2020-2021 онд НДШ төлөлтийн чөлөөлтөд хамрагдсан ААНБ-ийн даатгуулагч    | 32              |
| 23 | 2020-2021 онд НДШ төлөлтийн чөлөөлтөд хамрагдсан сайн дурын даатгуулагч  | 32              |

## Дүрслэлийн товьёг

| № | Тайлбар                                                              | Хуудасны дугаар |
|---|----------------------------------------------------------------------|-----------------|
| 1 | ЗДҮАХ-т иргэд, олон нийтээс авсан саналын судалгаа                   | 10              |
| 2 | хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрийн судалгаа | 22              |
| 3 | МБСБ-ын санхүүжилт, суралцагчийн тоо                                 | 29              |
| 4 | МБСБ-ын нийт төгсөгч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин                     | 29              |
| 5 | МБСБ-ын суралцагчдад олгосон тэтгэлэг, хөдөлмөр эрхлэлт              | 30              |
| 6 | МБСБ-ын нийт төгсөгч, мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн тоо           | 30              |
| 7 | Дэмжлэгт хамрагдсан төсөл төрлөөр                                    | 31              |
| 8 | Ажилд зуучлуулж, ажилд ороогүй иргэдийн шалтгаан                     | 33              |
| 9 | Дархан-Уул аймгийн хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн хувь                  | 34              |

## Зургийн товьёг

| № | Тайлбар                                           | Хуудасны дугаар |
|---|---------------------------------------------------|-----------------|
| 1 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төв | 17              |

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                           | <b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>     | <p>Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 2022 оны А/12 дугаар тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>Аудитын зорилт</b>                     | <p>Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх;</li><li>• Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх.</li></ul> |
| <b>Аудитын хамарсан хүрээ</b>             | <p>Аудитад Дархан-Уул аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл, ХХҮГ, Уул уурхай, эрчим хүчний политехник коллеж, Дархан өргөө политехник коллеж, Дархан-Уул аймаг дахь политехник коллеж зэрэг байгууллагын 2016-2021 оны аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b> | <p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах шалгагдагч байгууллагаас авсан бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан шалгаж, нөхцөл байдлын шинжилгээ хийж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.</p>                                                                                                                                                                                                                                                                                         |
| <b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>       | <p>Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, ахлах аудитор У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Алтанзул, З.Мөнгөнцэцэг, О.Мягмарсүрэн нар гүйцэтгэсэн.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Хүндрэл бэрхшээл</b>                   | <p>Аудитад сүүлийн 6 жилийн арга хэмжээ хамруулснаар аудитын хугацаа богино, олон аудит зэрэг эхэлсэн, боловсон хүчний дутагдалтай, шалгагдагч байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүд ажлаас халагдсанаар зарим материал олдохгүй байх зэргээс шалтгаалж аудит хийж, дүгнэлт гаргахад хүндрэлтэй байлаа.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |

## Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:



### ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1/05

Дархан сум

#### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Дархан-Уул аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Дархан сумын Засаг дарга, Шарын гол сумын Засаг дарга, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Засаг дарга, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл /Б.Азжаргал/, Дархан сумын Засаг дарга /Т.Тулгаа/, Шарын гол сумын Засаг дарга /Б.Лхамсүрэн/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /С.Энхболд/-т зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгч, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын баг /аудитор Б.Алтанзул/-т үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /У.Батсүрэн/-т даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

000019024

D:\Бичиг хэрэг\TUSHAAL.docx

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудиторов 2022 оны 02 дугаар сарын 02-ны  
өдрийн 02/02 дугаар тушаалын хавсралт



Аудитаар тогтоосон төлбөрийн акт,  
албан шаардлагын жагсаалт

/мянган төгрөг/

| №    | Төлбөр, зөрчил хариуцах байгууллага    | Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                   | Дугаар                           | Төлбөрийн актын дүн | Албан шаардлагын дүн |
|------|----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|---------------------|----------------------|
| 1    | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | "Кью Энд Эс" ХХК-тай байгуулсан өрхийн бизнес эрхлэн орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй зорилтот эмэгтэйчүүдэд зориулсан гар урлалын сургалтын гэрээний 1.3, 3.1 дэх заалтуудыг зөрчин 570.0 мянган төгрөгийг илүү олгосон | 75/A0970284/ДАА-2022/20-7-ШТА-ГА | 570.0               | -                    |
| 2    | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Аймгийн ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс түүвэрт хамрагдсан 17 иргэн, ААБН-ын 145,355,000 төгрөгийн зээлийн хугацаа дууссан ч төлөлт хийгдээгүй                                                            | 54/A0970284/ДАА-2022/20-7-ШТА-ГА | -                   | 145,355.0            |
| 3    | Шарын гол сумын Сум хөгжүүлэх сан      | Шарын гол сумын Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдсан иргэдээс 13 иргэний 26,414,240.86 төгрөгийн зээлийн хугацаа дууссан ч төлөлт хийгдээгүй                                                                       | 53/A0971061/ДАА-2022/20-7-ШТА-ГА | -                   | 26,414.2             |
| 4    | Дархан сумын Сум хөгжүүлэх сан         | Дархан сумын Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдсан иргэдээс 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 45,297,261 төгрөгийн зээлийн хугацаа дууссан ч төлөлт хийгдээгүй                                                    | 52/C010290/ДАА-2022/20-7-ШТА-ГА  | -                   | 45,297.3             |
| Нийт |                                        |                                                                                                                                                                                                                      |                                  | 570.0               | 217,066.5            |

—ooOoo—

## БҮЛЭГ А. ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН УЯЛДАА ХАНГАГДСАН БАЙНА

А.1. Үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой орон нутгийн бодлого, чиглэл уялдаатай байна

А.1.1. Дархан-Уул аймгийн хөгжлийн бодлого, зорилтууд төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах дунд хугацааны бодлоготой уялдсан байна

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.5<sup>1</sup>-д аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн баримт бичгийг тодорхойлсон бол 2021 оны шинэчилсэн найруулгын 4.1.10<sup>2</sup>, 4.1.11<sup>3</sup>-д дээрх бодлогын баримт бичгийг томъёолсон байна.

Дархан-Уул аймаг төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 25 зорилт, 44 арга хэмжээ, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Залуучуудын боловсрол хөгжил”, “Халамжаас хөдөлмөрт” зэрэг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн эсэх, харилцан уялдааг хангасан эсэхийг зорилт нэг бүрээр зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийхэд нийт 25 зорилтоос 8 зорилт нь төрөөс хэрэгжүүлэх бодлогын асуудал буюу хууль, эрх зүйн орчны зохицуулалтаар хэрэгжих, 10 зорилт нь шууд тусгагдсан<sup>4</sup>, 7 зорилт нь агуулгын хувьд уялдсан<sup>5</sup> байна. Энэ нь Дархан-Уул аймгийн хөгжлийн бодлого, зорилго, зорилтууд Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах дунд хугацааны бодлоготой 100 хувь уялдсан байна.

Хүснэгт 1. МУ-ын 2016-2014 оны дунд хугацааны бодлого, орон нутгийн ХБББ-ийн уялдаа

| Бодлогын баримт бичгийн нэр                                        | Нийт зорилтын тоо | Үүнээс          |                        |                   |                         |
|--------------------------------------------------------------------|-------------------|-----------------|------------------------|-------------------|-------------------------|
|                                                                    |                   | Шууд тусгагдсан | Агуулгын хувьд уялдсан | Огт тусгагда агүй | Орон нутагт хамааралгүй |
| Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого                | 5                 | 2               | 2                      | 0                 | 1                       |
| Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 12                | 5               | 4                      | 0                 | 3                       |
| Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 8                 | 3               | 1                      | 0                 | 4                       |
| <b>НИЙТ</b>                                                        | <b>25</b>         | <b>10</b>       | <b>7</b>               | <b>0</b>          | <b>8</b>                |

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

А.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг шаардлагатай үед хийгээгүй байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд их дээд сургууль, МБСБ-ийн багш нарын баг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, аймгийн ХХҮГ зэрэг байгууллагууд хамтран Дархан-Уул аймагт 2017 онд анх удаагаа ХЗЗ-ийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлын талаарх судалгаа хийсэн байна.

<sup>1</sup> “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж бүсчилсэн хөгжлийн бодлого болон аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод суурилсан, орон нутгийн сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийг тусгасан, орон нутгийн хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

<sup>2</sup> “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

<sup>3</sup> “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” гэж орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;

<sup>4</sup> Шууд тусгагдсан гэдэг үнэлгээ нь бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтын агуулга яг давхцаж байгаа.

<sup>5</sup> Агуулгын хувьд уялдсан гэдэг үнэлгээ нь зорилтын агуулгын зарим хэсгүүд тусгагдсан, эсвэл арай өөр хэлбэрээр илэрхийлсэн боловч агуулгын хувьд нийцсэн.

Судалгаагаар аймгийн ХЗЗ-ийн өнөөгийн байдал, эрэлт, нийлүүлэлтэд харьцуулалт хийж аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын болон хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, ХХҮГ, мэргэжлийн холбоод, ТББ-уудад хөдөлмөрийн зах зээлийн судалгааг жил бүр тодорхой давтамжтайгаар аймгийн хэмжээнд хийх зөвлөмж гаргасан боловч 2017 оноос хойш ХЗЗ-ийн судалгаа хийгдээгүй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд ХЗЗ-ийн судалгаа чухал ач холбогдолтой бөгөөд аймгийн дунд хугацааны бодлого боловсруулсны дараа хийсэн нь үр дүнгүй байлаа.

#### А.1.3 Дархан-Уул аймгийн ЗДҮАХ-ийг боловсруулахдаа бүх талуудын оролцоог хангасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 5.2.13<sup>6</sup>-т заасны дагуу Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг иргэд, олон нийтээс санал авсан байдлыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1. ЗДҮАХ-т иргэд, олон нийтээс авсан саналын судалгаа



Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 4,135 санал нэгтгэснээс 7.2 буюу 298 санал нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой санал байна.

Харин аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөхцөл байдлаас хамаарч төрийн байгууллагууд болон цахим хуудас, нийгмийн сүлжээгээр нийт 2,684 санал авснаас 2.6 хувь буюу 71 санал нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр ирүүлжээ. Эндээс аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу бүх талын оролцоонд үндэслэн боловсруулжээ гэж дүгнэж үзэхээр байна.

#### А.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

##### А.2.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх төсвийн тооцоолол тодорхойгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1<sup>7</sup>-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 7 зорилт, 20 арга хэмжээг нийт 9,115,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Гэсэн хэдий ч аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд дараах арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийг тодорхойлоогүй байна. Үүнд:

<sup>6</sup> бүх талын оролцоог хангасан байх зарчим" бол "хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байхыг

<sup>7</sup> Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна

- Аймгийн хэмжээнд эрэлттэй байгаа авто зам гүүр барилгын ажилчин-замчин чиглэлээр 105 мэргэжилтэн бэлтгэн гаргах
- Зорилтот бүлгийн 1,200 өрхийн хөдөлмөрийн насны иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зэрэг арга хэмжээ байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээнд гүйцэтгэлээр 3,892,500.0 мянган төгрөг зарцуулж, 42.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан нь аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна. (Хавсралт 4)

Мөн аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тооцоог судалгаа, шинжилгээнд үндэслэсэн эсэх нь баримтаар нотлогдоогүй болно.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 7 зорилт, 24 арга хэмжээг нийт 7,708,400.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. (Хавсралт 5)

Аудитаар арга хэмжээний төлөвлөлтийн тооцоог тулган шалгахад “Халамжаас хөдөлмөрт” дэд хөтөлбөр болон “Оюутны цагийн ажил” төсөлд зарцуулах хөрөнгийн тооцоо, судалгааг хийсэн боловч бусад арга хэмжээний зардлын төсөвлөлт баримтаар нотлогдоогүй болно.

**A.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын санхүүжилтэд орон нутгийн оролцоо хангалтгүй байна.**

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1-18.2.6<sup>8</sup>-д хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1<sup>9</sup>-д хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн эх үүсвэрийг тус тус тодорхойлсон.

Мөн Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “ХЭДС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.2-т “Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гэвч аймгийн ХЭДС-ийн дэд санд 2016-2021 онд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй боловч аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 91.7 хувийг ХЭДС-аас санхүүжүүлжээ.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Халамжаас хөдөлмөрт” дэд хөтөлбөр, “Орон нутгийн онцлогт нийцүүлсэн зорилтот төсөл”-ийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 1,200,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн боловч аймгийн 2021 оны төсөвт батлаагүй байна.

Хүснэгт 3. Санхүүжилтийн эх үүсвэрийн судалгаа /мянган төгрөг/

| Санхүүжилтийн эх үүсвэр | ЗДҮАХ 2017-2020    | ЗДҮАХ 2021-2024    |
|-------------------------|--------------------|--------------------|
| Орон нутгийн төсөв      |                    | 1,200,000.0        |
| Улсын төсөв             | 750,000.0          |                    |
| ХЭДС                    | 8,362,000.0        | 4,700,400.0        |
| ОНХС                    | 3,000.0            |                    |
| Бусад                   |                    | 1,808,000.0        |
| <b>Нийт дүн</b>         | <b>9,115,000.0</b> | <b>7,708,400.0</b> |

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

<sup>8</sup>18.2.1.улсын болон орон нутгийн төсөв, 18.2.2.гадаадын зээл, тусламж, 18.2.3.гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, 18.2.4.Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, 18.2.5.концессын гэрээ, 18.2.6.бусад эх үүсвэр.

<sup>9</sup> 22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, 22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, 22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, 22.1.4.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр, 22.1.5.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл, 22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж, 22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;

**А.2.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв батлагдаагүйгээс зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.**

Аймгийн дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх эх үүсвэрийн 70-90 хувийг ХЭДС-ийн дэд сангийн төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд жил бүр ХЭДС-ийн орлогын биелэлтээс хамаарч эхний 4 сард санхүүжилт олгогдоогүйгээс хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээ цаг хугацаандаа хийгдэхгүй байна.

Мөн аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан төсөв батлагдаагүйгээс доорх арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- Орон нутгийн төсвөөс хэрэгжих орон нутгийн онцлогт нийцүүлсэн зорилтот төслийг хэрэгжүүлж, иргэдэд илтгэлийн зээл олгох
- Орон нутгийн төсвөөс хэрэгжих “Халамжаас хөдөлмөрт” дэд хөтөлбөр

**А.3. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна**

**А.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө харилцан уялдаатай байна**

Аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг аймгийн ЗДТГ, НБХ, сумдын ЗДТГ, ХХҮГ зэрэг байгууллагууд хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4. ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын жагсаалт, арга хэмжээний тоо

| №           | Үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын нэр | ЗДҮАХ 2017-2020 оны арга хэмжээний тоо | ЗДҮАХ 2021-2024 оны арга хэмжээний тоо |
|-------------|----------------------------------------------------|----------------------------------------|----------------------------------------|
| 1           | АЗДТГ                                              | -                                      | 7                                      |
| 2           | НБХ                                                | 9                                      | 1                                      |
| 3           | Сумдын ЗДТГ                                        | 1                                      | 1                                      |
| 4           | ХХҮГ                                               | 19                                     | 10                                     |
| <b>Нийт</b> |                                                    | <b>29</b>                              | <b>19</b>                              |

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

Аудитаар дээрх байгууллагуудын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ЗДҮАХ-г хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан эсэхийг шалгахад төлөвлөгөөнүүд харилцан уялдаатай тусгагдсан байна.

**А.3.2. Орон нутгийн онцлогт тохирсон зохицуулалтыг бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна**

Дархан-Уул аймгийн дунд хугацааны бодлогыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт үндэслэн боловсруулснаас гадна орон нутгийн онцлогт тохирсон дараах арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээнд тусгасан байна. Үүнд:

- “Залуучуудын боловсрол, хөгжил” дэд хөтөлбөр
- “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” дэд хөтөлбөр
- “Халамжаас хөдөлмөрт” дэд хөтөлбөр
- Аймгийн хэмжээнд эрэлттэй байгаа авто зам гүүр барилгын ажилчин-замчин чиглэлээр мэргэжилтэй ажилтныг бэлтгэж, ажлын байраар хангах зэрэг арга хэмжээнүүд нэмж тусгагджээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ,

үнэлгээний хэлтэс жил бүр үнэлгээ хийсэн байна. Харин ХЭДС-ийн 2016-2021 оны зарцуулалтад ямар байгууллагууд хяналт шалгалт хийснийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. ХЭДС-ийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн байгууллагын жагсаалт

| № | Байгууллагын нэр                               | Он   | Шалгалтын чиглэл                                  |
|---|------------------------------------------------|------|---------------------------------------------------|
| 1 | Санхүүгийн хяналт, аудитын алба                | 2017 | ХЭДС-ийн 2016 оны гүйцэтгэл                       |
| 2 | Мэргэжлийн хяналтын газар                      | 2017 | ХЭДС-ийн 2015, 2016 оны үйл ажиллагаа             |
| 3 | Мэргэжлийн хяналтын газар                      | 2018 | ХЭДС-ийн 2017, 2018 оны үйл ажиллагаа             |
| 4 | Санхүүгийн хяналт, аудитын алба                | 2019 | ХЭДС-ийн 2017, 2018, 2019 оны 1-5 сарын гүйцэтгэл |
| 5 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 2020 | ХЭДС-ийн 2019 оны үйл ажиллагаа                   |

Эх сурвалж: ХЭДС-ийн гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалт баримт 2016-2021

### А.3.3. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна

ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.1-д зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга, гишүүдэд 3.1.1<sup>10</sup>, 3.1.2<sup>11</sup>, 3.1.3<sup>12</sup>-т заасны дагуу Аймгийн Засаг даргын 2017 оны А/103, 2021 оны 01-А/197 дугаар захирамжаар хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийг тус тус шинэчлэн байгуулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаанд 2016-2021 онд нийт зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 15,710.6 мянга, бичиг хэрэг, бусад зардалд 2,532.1 мянга, нийт 18,243.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 6. ХЭАЗ-ийн 2016-2021 оны төсөв, гүйцэтгэлийн судалгаа

/мянган төгрөг/

| Он   | Төсөв           | Гүйцэтгэл       |                      |                    |
|------|-----------------|-----------------|----------------------|--------------------|
|      |                 | Нийт            | Гишүүдийн урамшуулал | Бичиг хэрэг, бусад |
| 2016 | 4,000.0         | 900.0           | 900.0                |                    |
| 2017 | 3,800.0         | 3,610.6         | 3,260.6              | 350.0              |
| 2018 | 4,000.0         | 3,700.0         | 2,700.0              | 1,000.0            |
| 2019 | 4,000.0         | 4,000.0         | 3,000.0              | 1,000.0            |
| 2020 | 3,032.1         | 3,032.1         | 2,850.0              | 182.1              |
| 2021 | 4,548.2         | 3,000.0         | 3,000.0              |                    |
| Нийт | <b>23,380.3</b> | <b>18,242.7</b> | <b>15,710.6</b>      | <b>2,532.1</b>     |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Аудитаар ХЭАЗ-ийн дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхийг шалгахад тус зөвлөл жилд 1-2 удаа хуралдаж, ХЭДС-ийн хөтөлбөр, төсөвтэй танилцах, ажлын төлөвлөгөө болон нийтийг хамарсан ажлын төсөлд хамрагдах иргэдийн тоо батлах, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн журамд өөрчлөлт оруулах, “орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийн итгэлийн зээлийн чиглэл, тавигдах шаардлага, шалгуурыг батлах, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дүгнэх зэрэг ажлуудыг голчлон хийж гүйцэтгэсэн байна.

Харин ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолоор баталсан ХЭАЗ-ийн дүрэмд заасан дараах эрх, үүргүүдийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах

<sup>10</sup> Төрийг төлөөлж Засаг дарга болон аймаг, нийслэл, дүүргийн боловсрол болон нийгмийн хөгжил, төсөв санхүүгийн байгууллагаас нийт гурван хүн;

<sup>11</sup> Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гурван хүн;

<sup>12</sup> Ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн ажил олгогчдын байгууллагаас гурван хүн;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого, зарлагын явц байдал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих

- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийг зэх зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаар мэдээллээр хангах

- Тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах

- Тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг ХЭҮЗ-д жил бүрийн 1 дүгээр сард ирүүлж байх зэрэг арга хэмжээнүүд байна.

ХЭДС-ийн орлого бүрдүүлэлт, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь ХЭАЗ чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой гэж дүгнэж байна.

**А.3.4. Зарим арга хэмжээний хэрэгжилтийг бодитой тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг журмын дагуу үнэлээгүй байна**

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан 7 зорилт, 20 арга хэмжээний хэрэгжилтийг 99.5 хувиар үнэлсэн байна.

Аудитаар дээрх 7 зорилт, 20 арга хэмжээний хэрэгжилтийг бодитой тайлагнаж, хяналт-шинжилгээ үнэлгээг журмын дагуу үнэлсэн эсэхийг тулган шалгахад дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа бодит тоо, мэдээнд үндэслэж тайлагнаагүй,
- Шалгуур үзүүлэлт буюу хүрэх түвшинд нийцүүлж, үнэн зөв тайлагнаагүй,
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.2.3-т **“хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах”** гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, бодитой үнэлээгүй байна. (Хавсралт 2)

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх 7 зорилт, 24 арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувиар үнэлснийг аудитаар шалгахад дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа бодит тоо, мэдээнд үндэслэж тайлагнаагүй.
- Хэрэгжээгүй арга хэмжээний гүйцэтгэлд хамааралгүй хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан.
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.2.3-т **“хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах”**, 5.2.4-т **“тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах”** заалтыг хэрэгжүүлээгүй, бодитой үнэлээгүй байна. (Хавсралт 3)

Үүнээс үзэхэд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан бодитой тайлагнадаггүй, аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс журамд заасны дагуу бодитой үнэлээгүй байна.

## БҮЛЭГ Б. САНГУУДЫН ХӨРӨНГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА

Б.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөтэй байна

Б.1.1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлжээ

Сүүлийн 6 жилийн байдлаар 16,774 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ үзүүлснээс ганцаарчилсан зөвлөгөөнд 4,393, бүлгийн сургалтад 12,381 иргэн хамрагдаж, төлөвлөгөөг 101.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. АМЧБО сургалтад хамрагдсан иргэдийн тоо

| Он         | Сургалтад хамруулахаар төлөвлөсөн иргэдийн тоо | Нийт сургалтад хамрагдсан тоо | Гүйцэтгэлийн хувь | Ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн тоо | Бүлгийн сургалтад хамрагдсан иргэдийн тоо |
|------------|------------------------------------------------|-------------------------------|-------------------|--------------------------------------------------|-------------------------------------------|
| 2016       | 1,800                                          | 1,655                         | 10.0              | 335                                              | 1,320                                     |
| 2017       | 1,500                                          | 1,898                         | 11.5              | 1,033                                            | 865                                       |
| 2018       | 3,446                                          | 3,439                         | 20.8              | 677                                              | 2,762                                     |
| 2019       | 5,460                                          | 5,460                         | 33.0              | 674                                              | 4,786                                     |
| 2020       | 2,126                                          | 2,126                         | 12.9              | 674                                              | 1,452                                     |
| 2021       | 2,196                                          | 2,196                         | 13.3              | 1,000                                            | 1,196                                     |
| <b>Дүн</b> | <b>16,528</b>                                  | <b>16,774</b>                 | <b>101.5</b>      | <b>4,393</b>                                     | <b>12,381</b>                             |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Ганцаарчилсан үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 26.6 хувь буюу 1,168 иргэнийг ажилд зуучилж түр болон байнгын ажлын байраар хангасан байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар “Ковид” цар тахалтай холбоотойгоор бүлгийн сургалтад хамрагдах иргэдийн тоо буурчээ.

ХЗЗ-ийн мэдээллийн нэгдсэн системийн “LMIS” программд 3,945 иргэн АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ганцаарчилсан үйлчилгээнд, 12,663 иргэн бүлгийн сургалт, зөвлөгөөнд хамрагдсанаар тайлагнасан нь санхүүгийн тайлангийн дүн мэдээнээс нийт 166 иргэнээр зөрүүтэй байна.

Ажилд зуучлах үйлчилгээнд 2016-2021 онуудад 6934 иргэн хамрагдаж төлөвлөгөөг 90.5 хувийн гүйцэтгэлтэйгээр санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн 6 жилийн байдлаар ХЗЗ-ийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ААНБ-аас ирүүлсэн 7,383 ажлын байрны захиалгад 6,614 иргэнийг түр болон байнгын ажлын байранд зуучилжээ.

Хүснэгт 8. Ажлын байрны захилга, ажилд зуучлах иргэдийн тоо

| № | Он         | ААН, байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалга | Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан | Түр ажлын байранд зуучилсан | Байнгын ажлын байранд зуучилсан |
|---|------------|---------------------------------------------------|--------------------------------------|-----------------------------|---------------------------------|
| 1 | 2016       | 1,494                                             | 1,344                                | 10                          | 1,334                           |
| 2 | 2017       | 1,194                                             | 1,199                                | 10                          | 1,189                           |
| 3 | 2018       | 1,074                                             | 1,013                                | 10                          | 1,003                           |
| 4 | 2019       | 1,057                                             | 1,041                                | 160                         | 881                             |
| 5 | 2020       | 1,223                                             | 1,053                                | 150                         | 903                             |
| 6 | 2021       | 1,341                                             | 964                                  | 353                         | 611                             |
|   | <b>Дүн</b> | <b>7,383</b>                                      | <b>6,614</b>                         | <b>693</b>                  | <b>5,921</b>                    |

Эх сурвалж: “LMIS” программ

ХЗЗ-ийн мэдээллийн нэгдсэн системийн “LMIS” программд 6,614 иргэн ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсанаар тайлагнасан нь санхүүгийн тайлангийн дүн мэдээнээс нийт 320 хүнээр дутуу мэдээлсэн байна.

Ажлын байранд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, зардлыг төлөвлөхдөө ХЗЗ-ийн эрэлт хэрэгцээнд бус өмнөх оны гүйцэтгэл, тоо мэдээнд үндэслэж байна.

#### Б.1.2. Цахим мэдээллийн сангийн бүртгэлийн ашиглалт хангалтгүйгээс тоо мэдээ зөрүүтэй тайлагнаж байна

Аймгийн хэмжээнд 2016-2022 онуудад хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэхэд нийт 156,354.2 мянган төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн мэдээллийг 2016 оноос Explorer.Net программын нэгдсэн баазад оруулснаар мэдээ тайланг программаар боловсруулж улирал, хагас, бүтэн жилээр бэлтгэдэг нэгдсэн программтай болсон байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангах Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем “LMIS” программд оруулах ажилгүй, сул ажлын байр, ажилд орсон иргэдийн тоо, шинэ ажлын байр болон ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө үйлчилгээ авсан иргэдийн тоо нь санхүүгийн тайлангийн тоо мэдээллээс зөрүүтэй тайлагнаж байна. Уг программын үйл ажиллагааны ажиллах горим нь доголдолтой, тайлан мэдээ авахад алдаа гарах зэргээс мэдээллийн сан бүрдүүлж чадахгүй байна.

Мөн мэргэжилтнүүдийг программ дээр ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх, тоо мэдээллийг зөв оруулж, зөрүүтэй байдлыг арилгах шаардлагатай байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-өөр 2018 онд ажлын байр, ажил хайгчдын мэдээллийг байршуулах гар утасны “ДАРХАН JOBS” аппликэйшн нэвтрүүлсэн ч 2021 оноос сайжруулалт, шинэчлэл хийх хөрөнгө байхгүйгээс зогссон байна.

#### Б.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан байна

Дархан-Уул аймгийн ХЭДС-ийн 2016-2021 онуудад нийтлэг үйлчилгээний зардалд 208,998.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 187,866.7 мянган төгрөг зарцуулж, 89.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн задаргааг хавсралт 6-аар харуулсан ба нийт нэгтгэлийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 9. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Нийтлэг үйлчилгээний нэр                                     | 2016-2021 он  |                  |               |                  |
|--------------------------------------------------------------|---------------|------------------|---------------|------------------|
|                                                              | хүн           | төлөвлөгөө       | хүн           | гүйцэтгэл        |
| Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 16,528        | 137,218.6        | 16,774        | 123,286.7        |
| Ажилд зуучлах үйлчилгээ                                      | 7,660         | 71,780.0         | 6,934         | 64,580.0         |
| <b>Дүн</b>                                                   | <b>24,188</b> | <b>208,998.6</b> | <b>23,708</b> | <b>187,866.7</b> |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд нийт 123,286.7 мянган төгрөг зарцуулснаас 71.4 хувь буюу 88,084.8 мянган төгрөгийг ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд, 28.6 хувь буюу 35,201.8 мянган төгрөгийг гарын авлага, бичиг хэрэг, цайны зардал, шатахуун зэрэг зардлуудад зарцуулсан байна.

Ажилд зуучлах үйлчилгээнд 64,580.0 мянган төгрөгийг зарцуулснаас 38.3 хувь буюу 24,740.0 мянган төгрөгийг зар сурталчилгаанд, 14.7 хувь буюу 9,482.4 мянган төгрөгийг ажил олгогчийн зөвлөгөөн, хөдөлмөрийн яармаг зохион байгуулах зардалд, 39.6 хувь буюу 25,579.8 мянган төгрөгийг гарын авлага, маягт хэвлүүлэх, бичиг хэргийн зардалд, 3.8 хувь

буюу 2,450.0 мянган төгрөгийг шатахууны зардалд, 3.6 хувь буюу 2,327.8 мянган төгрөгийг гар утасны сунгалтад тус тус зарцуулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд төлөвлөсөн зардлыг ААНБ-д сурталчлах, зөвлөгөө, мэдээллээр хангах, шинэ болон сул ажлын байрны мэдээлэл авах, хамтран ажиллах, иргэдийг түр болон байнгын, оюутан залуусыг цагийн ажилд зуучлах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”, “Хөдөлмөрийн яармаг”, “Халамжаас хөдөлмөрт өдөрлөг”, “Дархан түншлэл” аянд зарцуулсан байна.

## Б.2. Төсөл, хөтөлбөрүүдийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө сул байна

### Б.2.1. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжсэн байна

Дархан-Уул аймгийн хэмжээнд сүүлийн 6 жилд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаадын зээл, тусламжаар 84,518.5 мянган төгрөгийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлжээ.

Хүснэгт 10. Гадаадын зээл, тусламжийн орлогын задаргаа

/мянган төгрөгөөр/


| Санхүүжилтийн нэр                                        | Тайлант онд санхүүжих дүн |      |      |      |                 |                 | ДҮН             |
|----------------------------------------------------------|---------------------------|------|------|------|-----------------|-----------------|-----------------|
|                                                          | 2016                      | 2017 | 2018 | 2019 | 2020            | 2021            |                 |
| Дэлхийн банкны төсөл /ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр/ | -                         | -    | -    | -    | 38,627.1        | 25,751.4        | 64,378.5        |
| Цвейцарийн хөгжлийн агентлаг                             | -                         | -    | -    | -    | -               | 20,140.0        | 20,140.0        |
| <b>ДҮН</b>                                               |                           |      |      |      | <b>38,627.1</b> | <b>45,891.4</b> | <b>84,518.5</b> |

Эх сурвалж: ХЭДС-гийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Дэлхийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн хүрээнд 2020-2021 онд хэрэгжсэн “Ухаалаг ирээдүй - Залуусын үнэ цэнэ” төсөлд нийт 64,378.5 мянган төгрөгийг олгож, 20-34 насны залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй 512 иргэнийг 6 үе шаттай сургалтад хамруулснаас 65 иргэн ажилтай болж, 26 иргэн хувиараа хөдөлмөр эрхэлж, ХБИ-ий 3 төсөлд 12,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож 15 ажлын байр бий болгосон байна. Төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээг “ЦЭСБ-Аудит” ХХК-аар гүйцэтгүүлж, үйл ажиллагааг үнэлгээний дүнг 96 хувиар үнэлсэн байна.

“Швейцарын хөгжлийн агентлаг”-ийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтарсан “Интерншип-ажлын байран дээр дадлагажуулах туршилтын хөтөлбөр”-ийг 20,140.0 мянган төгрөгөөр санхүүжүүлж, нээлттэй оффис, ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө, бүлгийн сургалтын танхим байгуулж, “хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага” МНС 6620:2016 стандартын 5 дах заалтын дагуу иргэдэд үйлчлэх үйлчилгээ тав тухтай, тохилог орчин бүрдүүлжээ.

Зураг 1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төв



Сургалтын танхим



Ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө

Мөн гадаадын зээл тусламжаас гадна 4 сумын Сум хөгжүүлэх сангаас 2016-2021 онуудад иргэд өрхийн үйлдвэрлэлээ өргөжүүлж, байнгын ажлын байртай болох зорилготой нийт 464 иргэн, ААНБ-д 3,972,100.0 мянган төгрөгийн зээл олгож, нийт 858 ажлын байр бий болгосон байна.

Хүснэгт 11. СХС-аар бий болсон ажлын байрны судалгаа /мянган төгрөгөөр/

| № | Сумдын нэр  | Зээлд хамрагдсан иргэд, ААНБ-ын тоо | Олгосон зээл /мян.төг/ | Үндсэн ажлын байрны тоо | Түр ажлын байрны тоо |
|---|-------------|-------------------------------------|------------------------|-------------------------|----------------------|
| 1 | Дархан      | 259                                 | 2,335,100.0            | 278                     | 152                  |
| 2 | Орхон       | 87                                  | 348,000.0              | 67                      | 29                   |
| 3 | Хонгор      | 46                                  | 501,600.0              | 92                      | 48                   |
| 4 | Шарын гол   | 72                                  | 787,400.0              | 153                     | 39                   |
|   | <b>Нийт</b> | <b>464</b>                          | <b>3,972,100.0</b>     | <b>590</b>              | <b>268</b>           |

Эх сурвалж: Сумдын СХС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

СХС-ийн зээлийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 1,519,352.4 мянган төгрөг байгаагаас 80.1 хувь нь хэвийн, 5.1 хувь нь хугацаа хэтэрсэн, 14.8 хувь нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжсэн байна.

Хүснэгт 12. Зээлийн үлдэгдлийн судалгаа /мянган төгрөгөөр/

| № | Сумдын нэр  | Зээлийн үлдэгдэл   | Үүнээс хугацаандаа | Хугацаа хэтэрсэн | ШШГГ             |
|---|-------------|--------------------|--------------------|------------------|------------------|
| 1 | Дархан      | 775,927.3          | 620,957.5          | 45,897.3         | 109,072.5        |
| 2 | Орхон       | 213,147.9          | 170,754.0          | 4,157.3          | 38,236.6         |
| 3 | Хонгор      | 181,165.6          | 121,222.0          | -                | 59,943.6         |
| 4 | Шарын гол   | 349,111.6          | 303,596.0          | 26,414.2         | 19,101.4         |
|   | <b>Нийт</b> | <b>1,519,352.4</b> | <b>1,216,529.5</b> | <b>76,468.8</b>  | <b>226,354.1</b> |

Эх сурвалж: Сумдын СХС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Аудитаар сумдын 516,162.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 64 иргэн, ААНБ-ыг түүвэрт хамруулж, 15 иргэний зээлийн материалыг, 49 иргэн, ААНБ-ын зээлийг газар дээр нь шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Зээлийн хугацаа дууссан ч зээлээ төлөөгүй Дархан сумын 5 иргэн, ААНБ-ын 45,297.3 мянга, Шарын гол сумын 10 иргэний 26,414.2 мянган төгрөг нь зээлийн гэрээний 7 дугаар зүйлийн 7.1.3 “зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зээлдэгчийн бизнесийн нэр хүндэд халдах, зээлийн өрийг гуравдагч этгээдэд шилжүүлэх / худалдах болон шаардлагатай гэж үзвэл Зээлдэгч болон батлан даагчийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг зээлийн төлбөрийг төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авах” гэсэн заалттай нийцэхгүй байгаад албан шаардлага хүргүүлэв.

2. Шарын гол сумын СХС-д зээлийн хугацаа дуусаагүй ч зээлийг хуваарийн дагуу төлөөгүй нийт 10 иргэний 2,573.4 мянган төгрөгийг төлүүлэх албан мэдэгдэл хүргүүлэх зөвлөмж өгөв.

3. Шарын гол сумын СХС-ын хяналтын зөвлөл нь хяналт тавих үүргээ биелүүлээгүй нь ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3-д “СХС-ийн хяналтын зөвлөлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг” гэсэн заалттай нийцэхгүй байна.

## Б.2.2. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө сул байна

Аймгийн ХЭДС-аас сүүлийн 7 жилд хэрэгжүүлсэн 6 төсөл хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 1,150 иргэнд 2,632,900.0 мянган төгрөг олгож, 2021 оны байдлаар 50.7 хувь буюу 1,336,559.7 мянган төгрөгийн зээл төлөгдөж, 440 иргэн, ААНБ-ын

1,233,125.2 мянган төгрөгийн зээлийн хугацаа болоогүй, 140 иргэний 63,215.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл байна.

Хүснэгт 13. ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэг

/мянган төгрөгөөр/

| Төсөл,<br>хөтөлбөрийн<br>нэр | АБДХ               | ЗХЭДХ            | МХЭДХ            | ХБИДХ            | АМЗҮ             | ОНОХНЗТ          | ДҮН                |
|------------------------------|--------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|--------------------|
| 2015 он                      | 97,500.0           | -                | 48,400.0         | -                | -                | -                | 145,900.0          |
| 2016 он                      | -                  | -                | 76,500.0         | -                | -                | -                | 76,500.0           |
| 2017 он                      | 195,000.0          | 29,500.0         | 55,000.0         | 60,000.0         | 42,500.0         | -                | 382,000.0          |
| 2018 он                      | 194,000.0          | 58,000.0         | 100,000.0        | 55,000.0         | 15,000.0         | 200,000.0        | 622,000.0          |
| 2019 он                      | 290,000.0          | 150,000.0        | 90,000.0         | 55,000.0         | 27,000.0         | 200,000.0        | 812,000.0          |
| 2020 он                      | 100,000.0          | -                | 50,000.0         | 32,500.0         | 24,000.0         | -                | 206,500.0          |
| 2021 он                      | 305,000.0          | -                | 20,000.0         | 36,000.0         | 27,000.0         | -                | 388,000.0          |
| <b>ДҮН</b>                   | <b>1,181,500.0</b> | <b>237,500.0</b> | <b>439,900.0</b> | <b>238,500.0</b> | <b>135,500.0</b> | <b>400,000.0</b> | <b>2,632,900.0</b> |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2021 оны санхүүгийн тайлан

Хүснэгт 14. ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэгийн зээлийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Төсөл,<br>хөтөлбөрийн<br>нэр | АБДХ             | ЗХЭДХ            | МХЭДХ            | ХБИДХ           | АМЗҮ            | ОНОХНЗТ          | ДҮН                |
|------------------------------|------------------|------------------|------------------|-----------------|-----------------|------------------|--------------------|
| 2015 он                      | 13,679.1         | -                | -                | -               | -               | -                | 13,679.1           |
| 2016 он                      | -                | -                | 1,119.6          | -               | -               | -                | 1,119.6            |
| 2017 он                      | 26,114.1         | 7,333.5          | 1,100.8          | 3,457.9         | 3,210.0         | -                | 41,216.4           |
| 2018 он                      | 53,712.8         | 20,803.0         | 38,940.5         | 15,115.9        | 860.0           | 161,965.5        | 291,397.7          |
| 2019 он                      | 153,834.8        | 99,418.0         | 47,540.0         | 29,400.0        | 6,964.0         | 137,299.7        | 474,456.6          |
| 2020 он                      | 79,746.0         | -                | 38,261.0         | 14,483.5        | 11,763.5        | -                | 144,254.0          |
| 2021 он                      | 259,598.2        | -                | 19,300.0         | 28,818.8        | 22,500.0        | -                | 330,216.9          |
| <b>ДҮН</b>                   | <b>586,685.0</b> | <b>127,554.5</b> | <b>146,261.9</b> | <b>91,276.1</b> | <b>45,297.5</b> | <b>299,265.2</b> | <b>1,296,340.3</b> |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2021 оны санхүүгийн тайлан

Аймгийн ХЭДС-аас 2021 оны байдлаар 138 зээлдэгчийн 43,246.9 мянга, 2022 оны эхний 3 сарын байдлаар шинээр 114,438.0 мянган төгрөгийн хугацаа зээлийн үлдэгдэлтэй 50 иргэнийг Шүүхийн шатанд шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн байна. Харин нас барсан 6 иргэний 5,373.0 мянга, сураггүй алга болсон 3 иргэний 1,895.0 мянга, таслан шийтгэх арга хэмжээ авагдсан 1 иргэний 1,895.0 мянга, 100 хувь хөдөлмөрийн чадвараа алдсан 1 иргэний 2,100.0 мянган төгрөгийн зээлүүд тус тус төлөгдөөгүй байна.

Аудитаар ХЭДС-аас 2015-2021 онд олгосон эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээс 2021 оны байдлаар зээлийн үлдэгдэлтэй 108 төсөл, хөтөлбөрийг түүвэрлэн авч тулган шалгахад үйл ажиллагаагаа явуулж байгаа 36 буюу 33.3 хувь нь хэвийн, нас барсан 2, ШШГА-д шилжүүлсэн 6, эвлэрлийн гэрээ байгуулсан 2 иргэн байгаа бол, үлдсэн 62 иргэн нь хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байлаа.

Аудитын явцад хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэдээс нийт 45,213.5 мянган төгрөгийг барагдуулснаас, 17,133.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 13 төслийг бүрэн төлүүлж төсөвт төвлөрүүлсэн. Мөн зээлийг графикайн дагуу төлөөгүй хугацаа хэтэрсэн 98,321.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 33 зээлдэгчдэд албан мэдэгдэл хүргүүлэх зөвлөмж өгөв.

Мөн зээлийн хугацаа дууссан, төлөлт хийгдээгүй 17 зээлдэгчийн 145,355.0 мянган төгрөгийг төлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн төлөлт хангалтгүй авлага жилээс жилд өссөөр байгаа нь зээлийн шалгаруулалт болон хэрэгжүүлэх явцад тавих хяналт сул

байгаагаас шалтгаалж байна. Иймээс цаашид мэргэжилтнүүдийн ажлын чиг үүргийн дагуу ажиллуулах, байгууллагын дотоод хяналтыг үр нөлөөг сайжруулан ажиллах шаардлагатай байна.

### Б.2.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулж 2021 оноос хөрөнгө баталж эхэлсэн байна

2016-2020 онуудад төсөл хөтөлбөр батлаагүйгээс Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.6-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх” гэсэн заалт хэрэгжээгүй байна.

2021 оны төсвийн тодотголоор “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ”-нд 2,000.0 мянган төгрөгийг нэмж баталжээ.

Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан сургалтын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулгаж, сургалтад хамрагдсан иргэдээс тодруулга авахад сургалт явуулах гэрээний 1 дүгээр зүйлийн 1.3-т “,,, 5 хоногт нийт 20 иргэдэд сургалт зохион байгуулах”-аар заасан заалтыг зөрчин 2 хоногийн хугацаанд 18 иргэн сургалтад хамруулсан зөрчил илэрч гэрээг дүгнэсэн акт, бусад санхүүгийн баримтыг үндэслэн сургалтын зардлыг 570,0 мянган төгрөг илүү олгосонд төлбөрийн акт тогтоов.

Сургалтыг мэргэжлийн бус байгууллага чанаргүй, гэрээнд заасан хугацааг баримтлаагүй зохион байгуулсан зэрэг шалтгаанаас сургалтын үр дүн муу байна.

### Б.3. Дэд сангийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, төрийн байгууллагуудтай хамтарч ажиллаагүй байна.

#### Б.3.1. Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, төрийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй байна

ХЭДС-ийн орлого улсын болон орон нутгийн төсвөөс гадна аж ахуйн нэгж, байгууллага гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөр, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөр, жижиг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрдэж байна. Аймгийн ХХҮГ-аас ХЭДС-ийн хөрөнгийн төлөвлөлтөд төсвийн төсөөллийг хийж хүргүүлснээр ХНХЯам, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс ХЭДС-д хөрөнгө хуваарилж, санхүүжилтийг олгодог байна.

Хүснэгт 15. Төсвийн төсөл, батлагдсан төсвийн харьцуулалт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                  | Хүргүүлсэн төсвийн төсөл | Батлагдсан төсөв   | Зөрүү               |
|---------------------------|--------------------------|--------------------|---------------------|
| Тайлант онд санхүүжих дүн | 2016 он                  | 1,124,440.0        | 1,459,582.1         |
|                           | 2017 он                  | 1,307,856.0        | 1,524,755.0         |
|                           | 2018 он                  | 2,403,585.0        | 2,015,839.2         |
|                           | 2019 он                  | 1,495,173.9        | 1,345,167.7         |
|                           | 2020 он                  | 2,511,330.0        | 1,078,441.9         |
|                           | 2021 он                  | 1,517,744.0        | 605,588.6           |
| <b>ДҮН</b>                | <b>10,360,128.9</b>      | <b>8,029,374.5</b> | <b>-2,330,754.4</b> |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Аймгийн ХЭДС-аас 2016-2021 онд 6 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхэд 10,360,128.9 мянган төгрөг төсөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 2016-2021 онуудад нийт 2,330,754.4 мянган төгрөгөөр бууруулан баталсан нь 2020-2021 онд цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор зарим төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг төлөвлөөгүйгээс шалтгаалжээ.

Аж ахуйн нэгж, байгууллага гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөрийн орлого нь тус газрын дансаар дамждаггүй, шууд ХХҮЕГ-т төвлөрдөг.

Хүснэгт 16. ХЭДС-ийн төсвийн бүрдүүлэлт

/мянган төгрөгөөр/


| №          | Гүйцэтгэлээрх орлогын дүн                         |                  |                    |                    |                    |                  |                    | Дүн                |
|------------|---------------------------------------------------|------------------|--------------------|--------------------|--------------------|------------------|--------------------|--------------------|
|            | Үзүүлэлт                                          | 2016 он          | 2017 он            | 2018 он            | 2019 он            | 2020 он          | 2021 он            |                    |
| 1          | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн санхүүжилт | 759,144.7        | 882,609.8          | 1,053,500.0        | 1,288,474.5        | 533,032.1        | 625,024.0          | 5,141,785.1        |
| 2          | Өмнөх оны үлдэгдэл                                |                  | 151,729.0          |                    |                    |                  | 179,346.1          | 331,075.01         |
| 3          | Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж |                  |                    |                    |                    | 64,540.6         | 56,416.4           | 120,957.0          |
| 4          | ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого               | 3,192.0          | 45,120.0           | 8,256.0            | 16,840.0           | 23,624.0         | 15,624.0           | 112,656.0          |
| 5          | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт                | 47,915.4         | 124,316.4          | 271,306.7          | 314,458.9          | 286,479.9        | 274,235.5          | 1,318,712.8        |
| 6          | Бусад                                             |                  | 37.5               | 1,200.0            |                    | 1,200.0          |                    | 2,437.5            |
| <b>Дүн</b> |                                                   | <b>810,252.2</b> | <b>1,203,812.7</b> | <b>1,334,262.7</b> | <b>1,619,773.4</b> | <b>908,876.6</b> | <b>1,150,646.0</b> | <b>7,027,623.6</b> |

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Дээрх 6 төсөл арга хэмжээнд улсын төсвөөс 33,080 иргэнд 8,029.374.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 33,343 хүнд 5,472.860.1 мянга, гадаадын зээл тусламжаас 120,957.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, хөдөлмөр эрхлэлтийн дэд санд 1,433,806.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

График 2. хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрийн судалгаа

/мянган төгрөг/



Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан

Аймгийн ХХҮГ-ын гаргаж ирүүлсэн судалгаагаар 2019-2021 онуудад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 25-аас дээш орон тооны ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага 122-148 байна. Мөн аймгийн Статистикийн хэлтсээс ирүүлсэн судалгаагаар

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 20-49 ажилтантай болон 50-иас дээш ажилтантай аж ахуй нэгжийн байгууллага дунджаар 193 аж ахуйн нэгж байна.

Эдгээр судалгаануудаас харахад аж ахуйн нэгж, байгууллагын тоо их байгаа ч ХБИ ажиллуулаагүйн төлбөр төлдөг байгууллага харьцангуй бага байна. Аймгийн ХХҮГ хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрөөс орох орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд анхаарал хандуулахгүй байгаа нь 2016-2021 онуудад 28 ААНБ-аас нийтдээ 112,656.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь дээрх графикаас харагдаж байна.

Аудитын явцад аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2021 оны жилийн эцсийн байдлаар 25-аас дээш даатгуулагчтай хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаггүй 27 ААНБ-ын судалгааг гаргуулан авч, Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн заалтуудын хэрэгжилтийг хангуулан ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт албан бичгээр хүргүүлсэн.

Үүний дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч төрийн 10, хувийн хэвшлийн 11 байгууллагыг хамруулан шалгалт хийснээр 6 байгууллагад 34,983.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн төлбөрийн акт тогтоосон. Аудитын явцад Голомт банк нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн ХЭДС-ийн дансанд 23,956.0 мянга, 4 ААНБ-аас 8,507.4 мянган төгрөгийг аймгийн ХЭДС-ийн дансанд байршуулан төлбөрийг барагдуулсан.

**Б.3.2. Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл итгэлийн зээлийг олон хүнд жижиг зээл хэлбэрээр олгосон нь зээлийн зориулалт алдагдан, чанаргүй зээл болжээ**

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг баталж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийг 2017-2018, 2019-2020, 2021-2022 онуудад баталсныг аймгийн ХЭДС үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.

Хүснэгт 17. ХЭҮЗ болон ХНХС-ийн баталсан тогтоол, удирдамж

| Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн тогтоол |                                         |                                                                                           |                             | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж |                                         |                             |
|--------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|-----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|-----------------------------|
| Он                                                                                         | Тогтоолын дугаар, огноо                 | Нэмэлт өөрчлөлт                                                                           | Хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо | Тушаал, огноо                                                                                                                   | Нэмэлт өөрчлөлт                         | Хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо |
| 2016                                                                                       | 2015.12.16-ны өдрийн 09 дүгээр тогтоол  |                                                                                           | 8                           | 2016.01.18-ны өдрийн А/12 дугаар тушаал                                                                                         |                                         | 7                           |
| 2017                                                                                       | 2017.01.27-ны өдрийн 01 дүгээр тогтоол  | 2017.03.21-ний өдрийн 03, 2018.01.19-ны өдрийн 01, 2018.06.27-ны өдрийн 03 дугаар тогтоол | 6                           | 2017.02.16-ны өдрийн А/26 дугаар тушаал                                                                                         | 2018.02.05-ны өдрийн А/19 дугаар тушаал | 6                           |
| 2018                                                                                       |                                         |                                                                                           |                             |                                                                                                                                 |                                         |                             |
| 2019                                                                                       | 2019.01.14-ны өдрийн 01 дүгээр тогтоол  | 2020.01.31-ны өдрийн 01, 2020.05.20-ны өдрийн 02 дугаар тогтоол                           | 6                           | 2019.03.05-ны өдрийн А/83 дугаар тушаал                                                                                         |                                         | 8                           |
| 2020                                                                                       |                                         |                                                                                           |                             |                                                                                                                                 |                                         |                             |
| 2021                                                                                       | 2021.02.09-ний өдрийн 01 дүгээр тогтоол | 2015.12.16-ны өдрийн 09 дүгээр тогтоол                                                    | 5                           | 2021.04.14-ны өдрийн А/49 дугаар тушаал                                                                                         |                                         | 7                           |

Эх сурвалж: www.hudulmur-halamj.gov.mn

Мөн ХЭҮЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 09-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”, 2020 оны 05 дугаар сарын 20-ны 02 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэх

“Хөдөлмөрийн зах зээлийн дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг шинээр баталсныг хэрэгжүүлж ажилласан байна.

**1.Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд:**

Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг 2016-2021 онуудад 43 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж 142 иргэнийг үйлдвэр дээрх сургалтад, мэргэжил олгох сургалтад 649 иргэнийг хамруулсан байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан ажил хайгч, мэргэжилгүй болон мэргэжлээ өөрчлөх хүсэл сонирхолтой иргэдийг тогооч, талх, нарийн боов, оёдол эсгүүр, газ оператор, хүүхэд асрагч, цахилгаанчин, гагнуурчин, гуталчин, зөөгч, хэвлэгч зэрэг мэргэжил олгох сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 118,555.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

**2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:**

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад, суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд чиглэгдсэн ажлын байрыг дэмжих хөтөлбөр зэрэг 9 арга хэмжээг 2016-2021 онд зохих журмын дагуу зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

Аудитын явцад АБДХ-ийн хүрээнд 2016-2021 онуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн зээл олголтыг ХЭҮЗ-ийн баталсан тогтоолын дагуу хуваарилсныг тулган шалгалаа.

Хүснэгт 18. Зээл олголт /мянган төгрөгөөр/

| зээл олгосон хэлбэр | 2016-2021 онуудад олгосон санхүүгийн дэмжлэг |                    |
|---------------------|----------------------------------------------|--------------------|
|                     | хүний тоо                                    | дүн                |
| 1,000.0             | 18                                           | 18,000.0           |
| 1,500.0             | 39                                           | 58,500.0           |
| 1,800.0             | 1                                            | 1,800.0            |
| 2,000.0             | 69                                           | 138,000.0          |
| 2,200.0             | 1                                            | 2,200.0            |
| 2,500.0             | 42                                           | 105,000.0          |
| 2,650.0             | 2                                            | 5,300.0            |
| 2,700.0             | 1                                            | 2,700.0            |
| 3,000.0             | 158                                          | 474,000.0          |
| 3,500.0             | 17                                           | 59,500.0           |
| 4,000.0             | 15                                           | 60,000.0           |
| 4,500.0             | 2                                            | 9,000.0            |
| 5,000.0             | 63                                           | 315,000.0          |
| <b>ДҮН</b>          | <b>428</b>                                   | <b>1,249,000.0</b> |

АБДХ-ийн хүрээнд санхүүгийн дэмжлэгийг 2016-2018 онуудад 1,000.0 - 1,800.0 мянган төгрөгөөр олгож, сүүлийн жилүүдэд 2,000.0 - 5,000.0 мянган төгрөгийн хооронд олгожээ. 2016 онд 85 иргэнд олгосон 165,000.0 мянган төгрөгийг 100 хувь эргэн төлөлтөөс чөлөөлсөн байна.

➤ ХЗЗ-ийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй ажил олоход хүндрэлтэй ажилгүй нийт 38 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажилласан 26 ААНБ-д 139,100.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

➤ Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээний хүрээнд 4 сумын 321 иргэнийг түр ажлын байраар хангаж, нийт 196,745.1 мянган төгрөгийг зарцуулсан байна

Энэ хөтөлбөрт тус сангаас 2016-2021 онуудад 2,564,512.6 мянган төгрөг төсөвлөснөөс 2,283,830.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онуудад нийт 325,500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосноос 2016 оны 20 иргэний 88,000.0 мянган төгрөгийг 100 хувь чөлөөлж, 237,500.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй, 36 сарын хугацаатай олгожээ.

Аудитын явцад ЗХЭДХ-ийн хүрээнд 2016-2021 онд санхүүгийн дэмжлэгт олгосон зээлийг ХЭҮЗ-ийн баталсан тогтоолын дагуу хуваарилсан эсэхийг тулган шалгасныг хүснэгтээр харуулав:

Хүснэгт 19. Зээл олголт

/мянган төгрөгөөр/

| зээл олгосон хэлбэр | 2016-2021 онуудад олгосон санхүүгийн дэмжлэг |                  |
|---------------------|----------------------------------------------|------------------|
|                     | хүний тоо                                    | дүн              |
| 2,000.0             | 1                                            | 2,000.0          |
| 2,500.0             | 1                                            | 2,500.0          |
| 3,000.0             | 11                                           | 33,000.0         |
| 4,000.0             | 18                                           | 72,000.0         |
| 6,000.0             | 1                                            | 6,000.0          |
| 10,000.0            | 21                                           | 210,000.0        |
| <b>ДҮН</b>          | <b>38</b>                                    | <b>325,500.0</b> |

ХЭҮЗ-ийн 2017 оны 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 5.1- д “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчийг хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилгоор тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад зориулж, нэг төгсөгчид 3 сая төгрөг, бүлэгт 10.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгоно” гэж заасныг зөрчин 2017 онд 2 иргэнд 2,000.0

мянга, 2,500.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих “Старт-Апп” арга хэмжээний сургалт зохион байгуулахад 2018, 2019, 2021 онуудад 38,364.0 мянга, “Старт-Апп” залуучуудад ментор хийхэд 8,000.0 мянган, борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээнд 4 байгууллагад 8,480.0 мянга, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 11 иргэнд 4,557.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ хөтөлбөрт тус сангаас 2016-2021 онуудад 490,610.0 мянган төгрөг төсөвлөснөөс 3 арга хэмжээ хэрэгжүүлээгүйгээс гүйцэтгэлээр 386,851.1 мянган төгрөгийг зарцуулжээ.

### 4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Малчдын хөдөлмөрийг дэмжих замаар цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгох 3 арга хэмжээнд 2016-2021 онуудад 499,560.0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс, 2016 онд “Шавь” сургалтын арга хэмжээ хэрэгжээгүйгээс гүйцэтгэлээр 493,403.4 мянган төгрөг зарцуулж, 6,156.6 мянган төгрөг хэмнэсэн байна.

Малчдын хөдөлмөрийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онуудад нийт 468,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосноос 2016 онд 34 иргэний 76,500.0 мянган төгрөгийг ХЭҮЗ-ийн 2015 онд баталсан 9 дүгээр тогтоолын баталсан 5 дугаар хавсралтын 2.2.3 дэх заалтын дагуу 50 хувь чөлөөлж, 391,500.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй, 24, 36 сарын хугацаатай олгосон байна. Аудитын явцад МХАДХ-ийн хүрээнд 2016-2021 онуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн зээл олголтыг ХЭҮЗ-ийн баталсан тогтоолын дагуу хуваарилсныг тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

### 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр:

ХБИ-ийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар 2016-2021 онуудад 12 арга хэмжээнд 622,024.0 мянган төгрөг батлагдаж,

гүйцэтгэлээр 507,431.0 мянган төгрөг зарцуулж, 60,926.0 мянган төгрөгийн 4 арга хэмжээ хэрэгжээгүйгээс 53,677.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онуудад нийт 367,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосноос 2016 оны 53 иргэний 60,000.0 мянган төгрөгийг 100 хувь чөлөөлж, 2020 оны 31 иргэний 32,500.0 мянган төгрөгийг ХЭҮЗ-ийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний нэмэлт, өөрчлөлтүүд”-ийн 4 зүйлийн 4.3-т заасны дагуу 50 хувь, 2021 онд 26 иргэний 36,000.0 мянган төгрөгийг ХЭҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 зүйлийн 5.1-т заасны дагуу 50 хувь тус тус чөлөөлж, 238,500.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй, 36, 48 сарын хугацаатай олгосон байна. Аудитын явцад ХБИАБДХ-ийн хүрээнд 2016-2021 онуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн зээл олголтыг ХЭҮЗ-ийн баталсан тогтоолын дагуу зээлийн хэмжээнд олгосныг тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

#### **6.Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр:**

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт тус сангаас 2016-2021 онуудад 257,140.0 мянган төгрөг төсөвлөснөөс 245,740.0 мянган төгрөгийг зарцуулж 11,400.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2017-2021 онуудад нийт 69 ахмадуудад эргэн төлөгдөх нөхцөлтэй 135,500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг, 36, 24 сарын хугацаатай олгосон байна. Аудитын явцад ХБИАБДХ-ийн хүрээнд 2016-2021 онуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн зээл олголтыг ХЭҮЗ-ийн баталсан тогтоолын дагуу хуваарилсныг тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

#### **7.Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл:**

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл нь бичил бизнес эрхлэгчид орон нутгийнхаа онцлогт нийцүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь хөнгөлөлттэй зээл олгож ажлын байр бий болгох, тогтвортой орлоготой болгохыг дэмжих зорилготойгоор эргэн төлөгдөх, хүүгүй, барьцаагүй, 36 сарын хугацаатай итгэлийн зээлийн хэлбэрээр 2018-2019 онд нийт 400,000.0 мянган төгрөг баталснаас, 2018 онд 28 иргэнд 100,000.0 мянга, 1 аж ахуйн нэгжид 100,000.00 мянга, 2019 онд 34 иргэнд 200,000.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Хүснэгт 20. Зээл олголт /мянган төгрөгөөр/

| зээл олгосон хэлбэр<br>/төгрөгөөр/ | 2018-2019 онуудад олгосон<br>итгэлийн зээл |                  |
|------------------------------------|--------------------------------------------|------------------|
|                                    | хүний тоо                                  | дүн              |
| 2,000.0                            | 1                                          | 2,000.0          |
| 2,500.0                            | 2                                          | 5,000.0          |
| 3,000.0                            | 16                                         | 48,000.0         |
| 5,000.0                            | 34                                         | 170,000.0        |
| 6,000.0                            | 1                                          | 6,000.0          |
| 7,000.0                            | 2                                          | 14,000.0         |
| 7,500.0                            | 2                                          | 15,000.0         |
| 10,000.0                           | 4                                          | 40,000.0         |
| 100,000.0                          | 1                                          | 100,000.0        |
| <b>ДҮН</b>                         | <b>63</b>                                  | <b>400,000.0</b> |

Аймгийн ХЭСЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот хурлын тэмдэглэлээр ОНОХНЗТ-ийн хүрээнд шалгаруулах төслийн тэргүүлэх чиглэл, тавигдах шаардлагыг хэлэлцэн баталсан боловч зөвлөлийн гишүүд нь орон нутгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо тооцоолол, үндэслэлд тулгуурлаагүй, хэлэлцсэн талаарх тэмдэглэл байхгүй байна. Мөн 2018 оны төсөл сонгон шалгаруулах комиссын хурлын тэмдэглэлд 2 иргэний талаар /Б.Гэрэлмаа, Ж.Энхжаргал/ авч

хэлэлцсэн тэмдэглэл байхгүй байхад зээл олгосон, зээл олгохын өмнөх хяналтыг хийгээгүй, тухайн иргэний төсөл хэрэгжүүлэх төлбөрийн чадвар, ямар үйл ажиллагаа явуулах гэж байгаа зэрэг үндэслэлийг судлаагүй олгосноор уг төслийн хэрэгжилт үр дүн муутай, эргэн төлөлтийн хугацаа хэтрэх гол шалтгаан нь болсон байна.

2018 онд зээл авсан 28 иргэнээс 5 иргэн зээлээ бүрэн төлж дууссан, 2022 оны 3 дугаар сарын байдлаар үлдсэн 23 иргэнийг шүүхийн байгууллагад шилжүүлсэн харин 2018 онд 100,000.0 мянган төгрөгийн зээл авсан “Элит хөгжил” ХХК нь 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 3,500.0 мянган төгрөгийг төлж, 96,500.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байхад шүүхэд шилжүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Үүнээс харахад зээлийг хэт жижиглэн, олон хүнд олгож төслийг үр дүнгүй болгох, хэрэгжихгүй байх шалтгаан нөхцөлийг бүрдүүлжээ.

**Б.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн 31.5 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна**

**Б.4.1 Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан журмыг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна**

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1<sup>13</sup>, 21.2<sup>14</sup> дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт, тавих журам”-ыг баталсан.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд Мэргэжлийн боловсрол, сургалтын дэмжих сангийн зарцуулалтыг төрийн өмчийн сургалтын байгууллагын тогтмол зардал, дотуур байрны зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хувьсах зардал, тэтгэлэг болон бусад төрлийн сургалт зохион байгуулах зардлыг санхүүжүүлэхээр зохицуулсан ч МБСДС-аас зөвхөн суралцагчдын тэтгэлгийн зардлыг санхүүжүүлж байна.

Хүснэгт 21. Дархан-Уул аймгийн МБСБ-ын санхүүжилт

/сая төгрөг/

| Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага | Санхүүжилтийн эх үүсвэр         | 2016    | 2017    | 2018    | 2019    | 2020    | 2021    |
|---------------------------------------------|---------------------------------|---------|---------|---------|---------|---------|---------|
| Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж     | Улсын төсвөөс                   | 1,281.2 | 1,157.8 | 1,101.7 | 1,293.5 | 1,219.6 | 1,374.1 |
|                                             | Үндсэн үйл ажиллагааны орлогоос | -       | 6.4     | 1.1     | 3.9     | -       | 9.5     |
| Уул уурхай, эрчим хүчний политехник коллеж  | Улсын төсвөөс                   | 1,131.1 | 1,158.3 | 1,178.8 | 1,407.1 | 1,640.3 | 1,637.1 |
|                                             | Үндсэн үйл ажиллагааны орлогоос | 6.6     | 0.2     | 7.8     | 0.7     | -       | -       |
| Дархан-Өргөө политехник коллеж              | Улсын төсвөөс                   | 1,483.6 | 1,681.5 | 1,593.5 | 1,952.6 | 2,177.9 | 2,158.9 |
|                                             | Үндсэн үйл ажиллагааны орлогоос | -       | 3.3     | -       | -       | 2.7     | 2.7     |

Эх сурвалж: МБСБ-ын 2016-2017 оны санхүүгийн тайлан

Дархан-Уул аймгийн МБСБ-ын санхүүжилтийн эх үүсвэрийн 99 хувийг улсын төсвийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1 хувийг тус тус эзэлж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2<sup>15</sup>-т заасны дагуу МБСДС-д орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулаагүй нь Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар төсөв батлаагүйтэй холбоотой байв.


<sup>13</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

<sup>14</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

<sup>15</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална.

Мөн Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор баталсан журмын 2.9<sup>16</sup> дэх хэсгийг Төсвийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

График 3. МБСБ-ын санхүүжилт, суралцагчийн тоо



Эх сурвалж: МБСБ-ын санхүүгийн тайлан, суралцагчийн мэдээ

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй МБСБ-ын суралцагчийн тоо 2017 онд 7.8 хувь, 2018 онд 14.5 хувь буурсан нь суралцагчид олгох тэтгэлгийг “Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”-ийн дагуу түр зогсоосонтой холбоотой байна. Харин Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоол<sup>17</sup>, 2020 оны 44 дүгээр тогтоолоор<sup>18</sup> МБСБ-ын суралцагчид тэтгэлэг олгож эхэлснээр 2021 онд суралцагчийн тоо 2519 болж 2018 оны суралцагчийн тооноос 38 хувиар өсжээ.

#### Б.4.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн 32.0 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь жил бүр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд мөшгөх судалгаа хийж байгаа хэдий ч цаашид үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад салбарт шинээр бий болгох ажлын байрны хэрэгцээг тодорхойлж, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхгүй байна.

График 4. МБСБ-ын нийт төгсөгч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Эх сурвалж: МБСБ-ын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа


<sup>16</sup> Сангийн хөрөнгийг Төрийн санд байршуулна. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 9.1.9-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр сангийн хөрөнгийг арилжааны банкны дансанд байршуулж болно.

<sup>17</sup> “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”

<sup>18</sup> “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”

МБСБ-ын 2016-2021 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаас үзэхэд нийт төгсөгчдийн 59.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа боловч 32.0 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна.

График 5. МБСБ-ын суралцагчдад олгосон тэтгэлэг, хөдөлмөр эрхлэлт



Эх сурвалж: МБСБ-ын тэтгэлэгийн мэдээ

МБСБ-ыг төгсөгчдийн тоо 2019 онд 7618, 2021 онд 986 буюу 29.5 хувиар өссөн нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор суралцагчид хичээлийн жилд сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 100,000 төгрөг, 2020 оны 44 дүгээр тогтоолоор 200,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ.

График 6. МБСБ-ын нийт төгсөгч, мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн тоо



Эх сурвалж: МБСБ-ын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа

МБСБ-ын 2019 онд төгсөгчдийн 39.4 хувь, 2021 онд 20.9 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байгаа нь суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ нэмэгдсэн буюу өссөн байхад ажилтай болсон төгсөгчдийн тоо буурсан байна.

МБСБ-ын суралцагчийн тоо жил ирэх тусам нэмэгдсэн ч ажилтай болсон төгсөгчдийн тоо буурсан нь Дархан-Уул аймгийн “Мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөл” нь “Мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөл”-ийн дүрмийн 3.2<sup>19</sup>, 3.3<sup>20</sup> дахь хэсэгт заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

<sup>19</sup> “Бүс, орон нутгийн мэргэжилтэй ажилчдын эрэлтийг судалж, тодорхойлох, хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа, үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх”

<sup>20</sup> “Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагын захиалгыг судалж, нэгтгэн МСҮТ-ийн сургалтад шинээр элсүүлэх захиалгын саналыг мэргэжил бүрээр гаргаж, зөвлөлөөр хэлэлцэн МБСГ-т хүргүүлж хамтран ажиллах”


Б.5. “Цар тахлын үед аж ахуй эрхлэлтийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд 2 дэд хөтөлбөр, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 8 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлжээ

Б.5.1. Ажилгүйдлийн даатгалын сангаас цар тахлын үед ажлын байраа хадгалсан ААНБ-ын даатгуулагчид 974,800.0 мянган төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна.

“Коронавируст халдвар /ковид-19/-ын царт тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.5<sup>21</sup>, “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн 3 дугаар зүйлд<sup>22</sup> заасны дагуу Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй 241 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор 4,874 ажилтанд 974,800.0 мянган төгрөгийн дэмжлэгийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон байна.

Дархан-Уул аймгийн ХХҮГ 2021 онд “Цар тахлыг үед аж ахуй эрхлэлтийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд батлагдсан 381,980.0 мянган төгрөгийн гүйцэтгэл 76.4 хувьтай буюу 291,980.0 мянган төгрөг байна. Дээрх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

График 7. Дэмжлэгт хамрагдсан төсөл төрлөөр



1. Санхүүгийн дэмжлэг 142,000.0 мянган төгрөгийг 37 иргэнд олгосон бөгөөд 43 хувь нь үйлчилгээ, 22 хувь нь аж ахуй эрхлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлжээ.

2. “Бизнесээ эхэл” аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалтыг Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Дархан-Уул төвтэй хамтран хэрэгжүүлж 150 иргэнийг хамруулсан.

3. Малчдыг малжуулах арга хэмжээний хүрээнд 5 иргэнд 20,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсэн.
4. Мал маллах арга ухааны сургалт, уулзалтыг Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран зохион байгуулж 19 иргэнийг хамруулсан.
5. 2020 онд гэрээ байгуулан ажил олоход хүндрэлтэй 3 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажилласан “Дархан Сондор Трейд” ХХК, “Дунд Бүрэн” ХХК-д урамшууллыг олгосон.
6. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах ажлын хүрээнд 9 төсөлд 344 иргэдийг хамруулж түр ажлын байраар хангасан.
7. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 80 иргэний бараа бүтээгдэхүүнийг ЖДҮ-дийг дэмжих Дархан-Уул төвийн борлуулалтын цэгээр дамжуулан борлуулсан байна.

<sup>21</sup> “Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх”

<sup>22</sup> “Коронавируст халдвар /Covid-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгоно”

8. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Хөрсгүй тариалалт” төсөл шилдэг “Старт-ап”-аар шалгарсан тул 10,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

“Цар тахлыг үед аж ахуй эрхлэлтийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд 2 дэд хөтөлбөр, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 8 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. Хэрэгжээгүй 1 арга хэмжээ нь иргэдэд цахим зээлийн үйлчилгээ /fintech/ нэвтрүүлэхээр тусгагдсан ч худалдан авах ажиллагаа болон цахим зээлийн үйлчилгээ үзүүлэх журам батлагдаагүйтэй холбоотой байна.

**Б.5.2. Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлийн дагуу нийгмийн даатгалын хөнгөлөлтөд 2021 онд давхардсан тоогоор ААНБ-ын 9,809 даатгуулагч хамрагдаж даатгуулагчийн тоо өмнөх оноос 4.8 хувиар өсжээ**

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21<sup>23</sup> дүгээр тогтоол, “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн 1<sup>24</sup> дүгээр зүйлд заасны дагуу даатгуулагчийн төлөх 14,863,607.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлсөн байна.

Хүснэгт 22. 2020-2021 онд НДШ төлөлтийн чөлөөлтөд хамрагдсан ААНБ-ийн даатгуулагч

| № | Үзүүлэлт |           |                    | Дүн         |
|---|----------|-----------|--------------------|-------------|
| 1 | 2020 он  | 4-9 сар   | Даатгуулагчийн тоо | 9,351       |
|   |          |           | Чөлөөлөлт          | 9,823,919.8 |
|   |          | 10-12 сар | Даатгуулагчийн тоо | 9,448       |
|   |          |           | Чөлөөлөлт          | 2,404,665.7 |
| 2 | 2021 он  | 1-6 сар   | Даатгуулагчийн тоо | 9,809       |
|   |          |           | Чөлөөлөлт          | 2,635,021.8 |

Эх сурвалж: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ

Мөн хуулийн 2<sup>25</sup> дүгээр зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан даатгуулагчийн 2,150,893.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тус тус чөлөөлжээ.

Хүснэгт 23. 2020-2021 онд НДШ төлөлтийн чөлөөлтөд хамрагдсан сайн дурын даатгуулагч

| № | Үзүүлэлт |           |                    | Дүн         |
|---|----------|-----------|--------------------|-------------|
| 1 | 2020 он  | 01-12 сар | Даатгуулагчийн тоо | 4,380       |
|   |          |           | Чөлөөлөлт          | 1,694,769.3 |
| 2 | 2021 он  | 1-6 сар   | Даатгуулагчийн тоо | 4,395       |
|   |          |           | Чөлөөлөлт          | 456,124.2   |

Эх сурвалж: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ

Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээр Дархан-Уул аймгийн нийгмийн даатгалд даатгуулагчийн тоо тогтмол өсч 2020 оны 4-9 дүгээр сард давхардсан тоогоор 9,351 даатгуулагч хөнгөлөлтөд хамрагдсан. Харин 2021 оны 1-6 сард давхардсан тоогоор 9809 даатгуулагч буюу 4.8 хувиар өссөн байна.

<sup>23</sup> “Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай”

<sup>24</sup> ...даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийн мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно,

<sup>25</sup> ...хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно.


### Б.5.3. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөлд 119 залуучуудыг хамруулснаас 63 хувийг байнгын ажлын байранд зуучилжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний 2 дугаар зорилгын 2.1-т “Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 3.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг батлан даалтын сангийн тогтолцоог ашиглан, банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгох” гэж заасны дагуу Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж 6 арилжааны банкаар дамжуулан 895 зээлдэгчид 52,618,560.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна.

Тус төлөвлөгөөний 2 дугаар зүйлийн 2.6-д “Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж, хөдөлмөрт бэлтгэх ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх” зорилгын хүрээнд ХХҮГ-ын даргын 2021 оны А/43 тоот тушаалаар “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийн ажлын хэсгийг байгуулсан. Төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн хөдөлмөрийн насны 315 залуучуудыг онлайнаар бүртгэн, ярилцлагын шатанд 176, эрүүл мэндийн үзлэгт 137 залуучууд хамрагдаж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэх сургалтад 123 иргэн хамрагдсан байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан иргэдийг ХХҮГ-ын албан хаагчид ажилд зуучлах хуваарийн дагуу 31 ажил олгогчтой гэрээ байгуулж, 119 иргэнийг дадлага хийлгэн 75 иргэнийг байнгын ажлын байртай болоход зуучлах ажлыг зохион байгуулжээ. Аудитаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдаж ажлын байранд дадлага хийсэн 119 иргэнтэй холбогдож, төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой тодруулгыг хийхэд ажилд зуучлуулсан 59 иргэн ажлын байрандаа тогтвор суурьшилтай хөдөлмөр эрхэлж байна.

График 8. Ажилд зуучлуулж, ажилд ороогүй иргэдийн шалтгаан



Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар


Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

### Б.5.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтөд судалгаа хийгдээгүй байна

Дархан-Уул аймгийн хүн амын тоо харьцангуй тогтвортой, нийт ажиллагчдын тоо 2019 онд 35,085 байсан бол 2020 онд 29,354 болж 16.3 хувиар буурж, 2021 онд 32,045 буюу өмнөх оноос 9.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. “Нийгмийн даатгалын шимтгэлээс

чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн 1<sup>26</sup> дүгээр зүйл, УИХ-ын 2020 оны 21<sup>27</sup> дүгээр тогтоолын дагуу хөнгөлөлтөд хамрагдсан даатгуулагчийн тоо 2020 оноос 2021 онд 4.8 хувиар өссөн нь нийт ажиллагчдын тоо 9.1 хувиар өсөхөд нөлөөлжээ.

График 9. Дархан-Уул аймгийн хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн хувь



Эх сурвалж: Дархан-Уул аймгийн нийгэм эдийн засгийн байдал 2016-2021 он

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Швейцарын хөгжлийн агентлагийн захиалгаар 2017 онд “Дархан-Уул аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”-г Дархан-Уул аймгийн их, дээд сургууль, МБС-ын байгууллагын багш нар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран хийсэн байна. Тус судалгааны дүнд үндэслэн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг жил бүр тодорхой давтамжтайгаар хийж гүйцэтгэхийг ХХҮГ, мэргэжлийн холбоодын төлөөлөлд зөвлөмжөөр хүргүүлсэн боловч хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтийн талаарх судалгаа хийгдээгүй байна. Дээрх судалгаа хийгдээгүй байгаа нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.2.6<sup>28</sup>-д заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<sup>26</sup> ....даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийн мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно,

<sup>27</sup> “Коронавируст халдвар /сovid-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай”

<sup>28</sup> “орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчид зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах”

Холбогдох байгууллагаас ирсэн санал:



45063 Дархан-Уул аймаг, Дархан сум 5-р баг  
Утас: 7037-5094, Факс: 7037-1137  
И-мэйл: info@darhan-uul.halamj.gov.mn  
Вэб: www.darhan-uul.halamj.gov.mn

2022.05.05 № 320

Тамга \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

ДАРХАН УУЛ АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

ДАРГА

С. ЭНХБОЛД

*С. Аюулууд*  
Аудитын байлалт  
хуриулав.

0452230618  
2/05  
2022 он.

*О.Мягмарсүрэн-г  
Завсгаарчтай Засаг дарга  
Хяналт бааруу.*

*Мтс  
3/05  
2022 он.*



**ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА**

4501 Дархан, Дархан сум, Өргөө баг,  
Дархан сумын Засаг даргын Тамгын газар  
Утас/Факс: 7037-3800  
E-mail: da.darhan.sum@gmail.com

2022. 05. 05 № 01/459

танил \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас ирүүлсэн “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан болно.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллахаа үүгээр мэдэгдэж байна.

**ЗАСАГ ДАРГА** *(Signature)* **Т.ТУЛГАА**



4500160602

D:Ajil.jijig toot-2022



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗӨВЛӨЛ**

Дархан-Уул аймаг Дархан сум

ХХҮГ-ын 102 тоот

Утас: 99372500

2022.05.05 № 01  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ДАРХАН УУЛ АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас ирүүлсэн “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

ДАРГА

Б.АЗЖАРГАЛ



З.Мамандзэвэг - г  
Аудитын тайланг  
тусгааран баталгаажуулж  
холбогдох байгууллагуудад  
ахруулье.  
2022 он .



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ШАРЫН ГОЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

45010 Шарын гол сум Дархан-Уул аймаг

Утас 7037-2528

E-mail: sharyngol\_zdtg@yahoo.com

2022.05.05 № 03/237  
танай 2022.05.05-ны № 306

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн “Төрөөс  
хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг  
нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын  
хэрэгжилт үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн тайлангийн  
төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд өгөх санал  
байхгүй болно.

ДАРГА  Г.ШИНЭХҮҮ

З.Мөнхнүцэг-т

Аудитын тайланг  
хурцувч.

4522020472

 5/05  
2022 он.

## ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Дархан-Уул аймгийн хөгжлийн бодлого, зорилтууд төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах дунд хугацааны бодлоготой уялдсан байна,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын санхүүжилтэд орон нутгийн оролцоо хангалтгүй байна,
- Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна,
- Зарим арга хэмжээний хэрэгжилтийг бодитой тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг журмын дагуу үнэлээгүй байна,
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна,
- Цахим мэдээллийн сангийн бүртгэлийн ашиглалт хангалтгүйгээс тоо мэдээ зөрүүтэй тайлагнаж байна,
- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжсэн байна,
- Төсөл, хөтөлбөрүүдийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө сул байна
- Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, төрийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй байна,
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн 31.5 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна,
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан журмыг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна,
- “Цар тахлын үед аж ахуй эрхлэлтийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд 2 дэд хөтөлбөр, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 8 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлжээ,
- Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөлд 119 залуучуудыг хамруулснаас 63 хувийг байнгын ажлын байранд зуучилжээ.

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:  
*Аймгийн Засаг дарга Б.Азжаргалд зөвлөж байна:*

1. Аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслэж байх
2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж, тодорхой давтамжтай хийх
3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг бодит тоо, мэдээнд үндэслэн тайлагнах, хэрэгжилтэд тавих үе шатны хяналтыг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээг баримт нотолгоо, мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, үнэлэх

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, журмын дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДС-д төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хөрөнгийг төвлөрүүлж байх

*“Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл”-ийн дарга Б.Азжаргалд зөвлөж байна:*

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг хэрэгжүүлж ажиллах.
2. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, орон нутгийн ААНБ-ын захиалгыг судалж, нэгтгэн МБСБ-ийн сургалтад шинээр элсүүлэх мэргэжлийн саналыг гаргаж, МБСБ-тай хамтран ажиллах

*ХХҮГ-ын дарга С.Энхболдод зөвлөж байна:*

1. ХЭДС-аас олгох санхүүгийн дэмжлэгийн төсөл сонгон шалгаруулах комиссын ажлыг сайжруулан, хууль журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулж байх
2. ХЭДС-аас төсөл, хөтөлбөрүүдийн хяналтыг сайжруулж, эргэн төлөлтийг хугацаанд нь төвлөрүүлж, хугацаа хэтэрсэн зээлдэгчийг шүүхийг байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах
3. Мэргэжилтнүүдийн программ дээр ажиллах ур чадварыг нэмэгдүүлэн тоо, мэдээллийг зөв оруулж, зөрүүтэй байдлыг арилгахад анхаарч ажиллах
4. Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг үндэслэлтэй бүрэн төлөвлөж, бүрдүүлэлтэд хяналт, тавьж ажиллах

*Дархан сумын Засаг дарга Т.Тулгаад зөвлөж байна:*

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах

*Шарын гол сумын Засаг дарга Б.Лхамсүрэнд зөвлөж байна:*

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэх

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2022.05.05

Хавсралт 1

|                     |                                                                                                                                                 |
|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ажлын баримтын нэр: | Алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл                                                                                                               |
| Аудитын код:        | ДАА-2022/20-7-ШТА-ГА                                                                                                                            |
| Аудитын нэр:        | “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит |

/Сая.төгрөгөөр/

| №                          | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                                                                                            | Хэрэгжилт тооцох хугацаа |             | Мөнгөн дүн | Хариуцах аудитор | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний |                                        |
|----------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-------------|------------|------------------|---------------------------------------|--------------------------------------------------------------------------|----------------------------------------|
|                            |                                                                                                                                                                                                                      | Хүлээлгэн өгсөн          | Барагдуулах |            |                  |                                       | Албан тушаал                                                             | Овог нэр                               |
| А                          | 1                                                                                                                                                                                                                    | 5                        | 6           | 7          |                  | 8                                     | 9                                                                        | 10                                     |
| <b>Төлбөрийн акт</b>       |                                                                                                                                                                                                                      |                          |             |            |                  |                                       |                                                                          |                                        |
| 1                          | “Кью Энд Эс” ХХК-тай байгуулсан өрхийн бизнес эрхлэн орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй зорилтот эмэгтэйчүүдэд зориулсан гар урлалын сургалтын гэрээний 1.3. 3.1 дэх заалтуудыг зөрчин 570.0 мянган төгрөгийг илүү олгосон | 4/25/2022                | 8/20/2022   | 0.6        | Б.Алтанзул       | Төлбөрийн акт тогтоох                 | Дархан-Уул аймгийн ХХҮГ-ын дарга, сангийн мэргэжилтэн                    | С.Энхболд Б.Гэрэлзам                   |
| <b>Төлбөрийн актын дүн</b> |                                                                                                                                                                                                                      |                          |             | <b>0.6</b> |                  |                                       |                                                                          |                                        |
| <b>Албан шаардлага</b>     |                                                                                                                                                                                                                      |                          |             |            |                  |                                       |                                                                          |                                        |
| 1                          | Аймгийн ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс түүвэрт хамрагдсан 17 иргэн, ААБН-ын 145,355,000 төгрөгийн зээлийн хугацаа дууссан ч төлөлт хийгдээгүй                                                            | 5/3/2022                 | 11/20/2022  | 145.3      | Б.Алтанзул       | Албан шаардлага өгөх                  | Дархан-Уул аймгийн ХХҮГ-ын дарга, ХЭХ-ийн дарга, сангийн мэргэжилтэн     | С.Энхболд Б.Гэрэлтзам Б.Сэрүүнтунгалаг |
| 2                          | Шарын гол сумын Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдсан иргэдээс 13 иргэний 26,414,240.86 төгрөгийн зээлийн хугацаа дууссан ч төлөлт хийгдээгүй                                                                       | 5/3/2022                 | 11/20/2022  | 26.4       | З.Мөнгөнцэцэг    | Албан шаардлага өгөх                  | Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга, нягтлан бодогч, ХЖДҮХАХМ | Б.Лхамсүрэн М.Отгон У.Алтанчимэг       |

|                             |                                                                                                                                                                                                                                                                                                  |          |            |              |               |                      |                                                                       |                                      |
|-----------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|------------|--------------|---------------|----------------------|-----------------------------------------------------------------------|--------------------------------------|
| 3                           | Дархан сумын Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдсан иргэдээс 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 45,297,261 төгрөгийн зээлийн хугацаа дууссан ч төлөлт хийгдээгүй                                                                                                                                | 5/3/2022 | 11/20/2022 | 45.3         | О.Мягмарсүрэн | Албан шаардлага өгөх | Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг дарга, нягтлан бодогч, ХЖДҮХАХМ | Т.Тулгаа<br>В.Пүрэвсүрэн<br>Б.Ундрах |
| <b>Албан шаардлагын дүн</b> |                                                                                                                                                                                                                                                                                                  |          |            | <b>217.0</b> |               |                      |                                                                       |                                      |
| <b>Зөвлөмж</b>              |                                                                                                                                                                                                                                                                                                  |          |            |              |               |                      |                                                                       |                                      |
| 1                           | Аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслэж байх                                                                                                                                                   | 5/5/2022 | 11/20/2022 | -            | 3.Мөнгөнцэцэг | Зөвлөмж өгөх         | Дархан-Уул аймгийн Засаг дарга                                        | Б.Азжаргал                           |
| 2                           | Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж, тодорхой давтамжтай хийх                                                                                                                                                              | 5/5/2022 | 11/20/2022 | -            | 3.Мөнгөнцэцэг | Зөвлөмж өгөх         | Дархан-Уул аймгийн Засаг дарга                                        | Б.Азжаргал                           |
| 3                           | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг бодит тоо, мэдээнд үндэслэн тайлагнах, хэрэгжилтэд тавих үе шатны хяналтыг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээг баримт нотолгоо, мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, үнэлэх                                                                       | 5/5/2022 | 11/20/2022 | -            | 3.Мөнгөнцэцэг | Зөвлөмж өгөх         | Дархан-Уул аймгийн Засаг дарга                                        | Б.Азжаргал                           |
| 4                           | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, журмын дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДС-д төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хөрөнгийг төвлөрүүлж байх                                                                                                                                            | 5/5/2022 | 11/20/2022 | -            | 3.Мөнгөнцэцэг | Зөвлөмж өгөх         | Дархан-Уул аймгийн Засаг дарга                                        | Б.Азжаргал                           |
| 5                           | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг хэрэгжүүлж ажиллах.                                                                                                                                               | 5/5/2022 | 11/20/2022 | -            | 3.Мөнгөнцэцэг | Зөвлөмж өгөх         | Дархан-Уул аймгийн Засаг дарга                                        | Б.Азжаргал                           |
| 6                           | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, орон нутгийн ААНБ-ын захиалгыг судалж, нэгтгэн МБСБ-ийн сургалтад шинээр элсүүлэх мэргэжлийн саналыг гаргаж, МБСБ-тай хамтран ажиллах | 5/5/2022 | 11/20/2022 | -            | 3.Мөнгөнцэцэг | Зөвлөмж өгөх         | Дархан-Уул аймгийн Засаг дарга                                        | Б.Азжаргал                           |

|                                |                                                                                                                                                                                                                             |          |            |              |               |              |                                                |             |
|--------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|------------|--------------|---------------|--------------|------------------------------------------------|-------------|
| 7                              | ХЭДС-аас олгох санхүүгийн дэмжлэгийн төсөл сонгон шалгаруулах комиссын ажлыг сайжруулан, хууль журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулж байх                                                                               | 5/5/2022 | 11/20/2022 | -            | Б.Алтанзул    | Зөвлөмж өгөх | Дархан-Уул аймгийн ХХҮГ-ын дарга               | С.Энхболд   |
| 8                              | ХЭДС-аас төсөл, хөтөлбөрүүдийн хяналтыг сайжруулж, эргэн төлөлтийг хугацаанд нь төвлөрүүлж, хугацаа хэтэрсэн зээлдэгчийг шүүхийг байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах                               | 5/5/2022 | 11/20/2022 | -            | Б.Алтанзул    | Зөвлөмж өгөх | Дархан-Уул аймгийн ХХҮГ-ын дарга               | С.Энхболд   |
| 9                              | Мэргэжилтнүүдийн программ дээр ажиллах ур чадварыг нэмэгдүүлэн тоо, мэдээллийг зөв оруулж, зөрүүтэй байдлыг арилгахад анхаарч ажиллах                                                                                       | 5/5/2022 | 11/20/2022 | -            | Б.Алтанзул    | Зөвлөмж өгөх | Дархан-Уул аймгийн ХХҮГ-ын дарга               | С.Энхболд   |
| 10                             | Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг үндэслэлтэй бүрэн төлөвлөж, бүрдүүлэлтэд хяналт, тавьж ажиллах                                                        | 5/5/2022 | 11/20/2022 | -            | Б.Алтанзул    | Зөвлөмж өгөх | Дархан-Уул аймгийн ХХҮГ-ын дарга               | С.Энхболд   |
| 11                             | Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах | 5/5/2022 | 11/20/2022 | -            | З.Мөнгөнцэцэг | Зөвлөмж өгөх | Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга | Б.Лхамсүрэн |
| 12                             | Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах | 5/5/2022 | 11/20/2022 | -            | О.Мягмарсүрэн | Зөвлөмж өгөх | Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг дарга    | Т.Тулгаа    |
| <b>Зөвлөмжийн дүн</b>          |                                                                                                                                                                                                                             |          |            | -            |               |              |                                                |             |
| <b>Алдаа зөрчлийн нийт дүн</b> |                                                                                                                                                                                                                             |          |            | <b>217.6</b> |               |              |                                                |             |

**Дархан-Уул аймгийн 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хөрөнгийн төсөв, гүйцэтгэл, тайлангийн шинжилгээ-4**

| №                                                                                                                                                                                  | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ                                                 | Нийт хөрөнгийн эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая.төг) | Шалгуур үзүүлэлт                                                     | Шалгуур үзүүлэлт тоо | Хэрэгжилт /тоо/ | Аудитаар /тоо/ | ХШҮДАХ үнэлгээ /хувь/ | Аудитаар /хувь/ | LMIS программ |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|---------------------------------|----------------------------------------------------------------------|----------------------|-----------------|----------------|-----------------------|-----------------|---------------|
| <b>Зорилт 6.1.9 Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн мэргэжилтэй ажилтныг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран бэлтгэж, төгсөгчдийг ажлын байраар хангана</b> |                                                                                                                                       |                          |                                 |                                                                      |                      |                 |                |                       |                 |               |
| 1                                                                                                                                                                                  | Аймгийн хэмжээнд эрэлттэй байгаа авто зам гүүр барилгын ажилчин-замчин чиглэлээр мэргэжилтэй ажилтныг бэлтгэж, ажлын байраар хангана. | -                        |                                 | Мэргэжилтэй 105 ажилтныг бэлтгэн гаргасан байна.                     | 105.0                | 60.0            | 16.0           | 100.0                 | 15.2            |               |
| <b>Зорилт 6.3.2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, байнгын ажлын байранд зуучлах замаар ажилгүйдлийн түвшинг бууруулна.</b>                                                          |                                                                                                                                       |                          |                                 |                                                                      |                      |                 |                |                       |                 |               |
| 1                                                                                                                                                                                  | Сангуудын болон ААНБ-ын өөрийн хөрөнгө оруулалтаар шинэ ажлын байрыг бий болгоно.                                                     | Бусад                    | 2,000.0                         | ЗГ-ын 2013 оны 154 дүгээр тогтоол, 6050 шинэ ажлын байр бий болгоно. | 6,050.0              | 6,052.0         | 5,468.0        | 100.0                 | 90.4            | 5,468.0       |
| 2                                                                                                                                                                                  | Ажилгүй, мэргэжилгүй иргэдийг байнгын ажлын байранд зуучилна.                                                                         | Бусад                    | 60.0                            | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 зүйл, 5000 иргэн          | 5,000.0              | 3,764.0         | 4,673.0        | 100.0                 | 93.5            | 4,673.0       |
| 3                                                                                                                                                                                  | Ажилгүй, ажил хайгч бүх насны иргэдийг амьжиргааг сайжруулах, хөгжүүлэх зорилгоор “Итгэлийн зээл”-д хамруулна.                        | Бусад                    | 300.0                           | Залуу, дунд, ахмад насны 300 иргэний амьжиргаа дээшилсэн байна.      | 300.0                | 616.0           | 63.0           | 100.0                 | 21.0            |               |
| <b>Зорилт 6.3.11. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.</b>                                                              |                                                                                                                                       |                          |                                 |                                                                      |                      |                 |                |                       |                 |               |
| 1                                                                                                                                                                                  | Зорилтот бүлгийн иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулна.                                                                                  | Бусад                    | 80.0                            | Нийгмийн халамжийн тухай                                             | 30,000.0             | 1,042.0         |                | 100.0                 | 3.5             |               |

|   |                                                                                       |       |       |                                                                 |         |         |         |       |      |  |
|---|---------------------------------------------------------------------------------------|-------|-------|-----------------------------------------------------------------|---------|---------|---------|-------|------|--|
|   |                                                                                       |       |       | хууль, 30,0<br>мянган өрх                                       |         |         |         |       |      |  |
